



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БАГА, СУУРЬ БОЛОВСРОЛЫН  
**ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ**

**ХӨГЖИМ**

УЛААНБААТАР 2021





БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БАГА, СУУРЬ БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

# ЗӨВЛӨМЖ

ХӨГЖИМ

*АНХНЫ ХЭВЛЭЛ*

УЛААНБААТАР 2021



## **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

---

Суралцагчийн үнэлгээ ..... 2

## **БАГА, СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН**

---

Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүйн зөвлөмж..... 5

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар ..... 11

Гурав. Нотолгоонд суурилан шинжилгээ хийх аргачлал..... 31

## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-г суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

<sup>1</sup> Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

<sup>2</sup> Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

<sup>3</sup> Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup> Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.






## Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүйн зөвлөмж

### БИД ЮУГ ҮНЭЛЭХ ВЭ?

1. Когнетив: Оюун ухаан (**мэдлэг** - knowledge)
2. Аффектив: Сэтгэл нийгэмшихүйн (**хандлага** - attitude)
3. Психомоторик: бие бялдар, эрүүл мэнд (**чадвар** - skills)

Үнэлгээ нь сурагчдын суралцахуйг сайжруулахын тулд багшийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, түүнийг хэрэглэх үйл ажиллагаа юм. Ингээд сургалт ба үнэлгээний хамаарлыг дараах схемээр үзүүлээ.



Суралцагчдын мэдлэг, чадвар эзэмшилтийн явц, үр дүнг тодорхойлж, сургалтын явцад хүүхдийн хөгжилд гарч буй ахицыг өмнөхтэй жишиж, харьцуулах түүнчлэн эзэмшвэл зохих агуулгыг ямар түвшинд эзэмшсэнийг тодорхойлоход оршино. Иймд үнэлгээ бол заах аргачлалыг сайжруулах хэрэгсэл юм.

Сургалтын өмнө сурагчдын мэдлэг, чадвар, сонирхлыг тодорхойлохын тулд сургалтын өмнөх үнэлгээ буюу “Оношлох үнэлгээ” хийх ба багшийн тухайн ангид сургалт явуулах үйл ажиллагааг төлөвлөхөд хэрэглэгддэг.

Явцын үнэлгээг сургалтын явцад хийх ба сурагчдын ахиц, амжилт, тэдгээрийн үр дүн, суралцахуйн болон багшлах үйл ажиллагааг тодорхойлоход хэрэглэнэ.

Эцсийн үнэлгээ нь багшлах үйл ажиллагааны тодорхой хугацааны төгсгөлд хийгдэх бөгөөд сурагчдын юу мэдсэн, ойлгосон, чадах вэ гэдгийг тодорхойлох үйл ажиллагаа юм.

Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур боловсруулах эрх зүйн үндэслэл юу вэ?

БСШУС-ын сайдын А/425 тушаал (2018), “ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д

- Суралцагчийн **үнэлгээ** нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөнөөс ангид, **шалгуурт суурилсан**, суралцагчийн сурах хүсэл эрмэлзлэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;
- Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх **шалгуурыг** боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж батлах;

Үнэлгээний шалгуур боловсруулахдаа дараах үзэл баримтлалыг баримталсан болно. Үүнд:

- Боловсролын таксономи болох Б.Блумын таксономи
- Вигссийн “Бүтээлч зохицол” буюу үйл ажиллагааны явцад сурагчид өөрсдөө мэдлэг бүтээх конструктив үзэл гэх мэт

Үнэлгээний шалгуур боловсруулахын ач холбогдол юу вэ?

- Суралцагчдад юу мэдэх, чадах хэрэгтэйг тодруулж өгөх;
- Суралцагчид суралцахуйн чухал, үнэ цэнтэй үр дүнд анхаарлаа хандуулах;
- Суралцагчид суралцахуйн үр дүнгийн өөр түвшинд хүрэхийн тулд юу хийх хэрэгтэйг ойлгох чадвартай болох;
- Багшлахуй, суралцахуйн зорилтыг нэгтгэхэд дэмжлэг үзүүлэх болно.

Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг дараах алхамчлалаар боловсруулсан болно.

А.Суралцахуйн зорилтыг задлан шинжлэх

Б.Нэгжийг төлөвлөх

В.Нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлох

Г.Гүйцэтгэлийн үзүүлэлт боловсруулах

Д.Жилийн суралцахуйн үр дүнг тодорхойлох

#### А. Суралцахуйн зорилтыг задлан шинжлэх

Үнэлгээ болон суралцахуй, багшлахуй нь суралцахуйн үр дүнд нийцсэн байна.

Сургалтын хөтөлбөрт суралцахуйн зорилтыг суралцагчийн эзэмших чадварын илэрхийлэл гэж үзээд төрх байдал, гүйцэтгэл, нөхцөл, шалгуур гэсэн суралцахуйн зорилтын томъёололд тавигдах шаардлагын дагуу SMART байхаар боловсруулсан байдаг. Жишээ нь:

5.4.а. Хөгжмийн зохиолын төрөл зүйлийг /дуулаач, дан хөгжим/ сонсож тодорхойлох зорилтыг шаардлагын дагуу шинжилж үзье.

- **Төрх байдал (behavior) буюу гүйцэтгэл – “тодорхойлох”**, сурагчид юуг хийх эсвэл бүтээх чадвартай болох вэ?
- **Нөхцөл – “Хөгжмийн зохиолын”**, мэдлэг, чадвараа ямар үйл дээр хэрхэн харуулах вэ? (ямар жишээ, кейс дээр харуулах)
- **Шалгуур – “төрөл зүйлийг /дуулаач, дан хөгжим/ сонсож”**, ямар багц шалгуураар сурагчийн эзэмшсэн тухайн мэдлэг, чадварыг харуулах вэ? (ямар арга онолоор шийдэх)

**Б. Нэгжийг төлөвлөх**

Өмнөх журмаар хичээлийн нэгж (40 минутыг), нэгж хичээл гэсэн 2 нэр томъёог хэрэглэж байсан. Нэгж хичээл гэдгийг ээлжит хичээлээ багцалсан эсвэл бүлгээ хуваасныг ойлгодог байв.

Сүүлийн үед үнэлгээ, үнэлгээний нэгж гэсэн нэр томъёо гарч ирлээ.

Бид нэгжийн төлөвлөлтийг хийхдээ жилийн судлах агуулгад баримжаалан 2-5 хүртэл ээлжит хичээлийн багтаамжтайгаар төлөвлөж ирсэн туршлагатай билээ. Энэ арга нь тогтсон агуулгаа гээхгүй мөрдөх давуу талтай ч зорилго, зорилт нь хэт жижиг олон нэгж хичээл төлөвлөж, олон удаа үнэлэх, хөтөлбөрийн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд бага анхаарах, үнэлэхгүй орхигдуулах сул талтай байдаг. Орчин үед хөтөлбөрийн зорилго, зорилтыг суралцахуйн үр дүн байдлаар жил, багцалсан нэгжид буулган боловсруулж үнэлэх хандлага давамгайлж байна. Гадаадын зарим орны хөтөлбөрөөс үзэхэд нэг хичээлийн жилд бүлгүүдийг нэгтгэн 5-8 хүртэл нэгжийг төлөвлөж байна. Энэ нь бага, суурь, бүрэн дундад бас ялгаатай байдаг.

Бага ангид нэгж гэдэг ойлголт байхгүй байж болно. Ер нь бага ангид хичээлийг ээлжит ба жилээр төлөвлөхөд хангалттай байдаг. Суурь ба бүрэн дунд боловсролд үнэлгээний нэгж чухал. Учир нь нэгж бүрээр албан ёсны үнэлгээ хийдэг. Тэгэхлээр суралцахуйн үр дүнг голлон нэгжилбэл үнэлгээний нэгж болох ба агуулгад суурилан төлөвлөсөн нь хичээлийн нэгж болдог байна. Үнэлгээний нэгжид хэд хэдэн бүлэг сэдэв хамаарагддаг. Гэсэн хэдий ч хөгжмийн хичээлийн цаг цөөн, бүлэг сэдэв нь үнэлгээний нэгжийг төлөөлөхүйц тул сургалтын хөтөлбөрийн бүлэг сэдвээр үнэлгээний нэгжийг төлөвлөсөн болно.

**В. Нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлох**

Суралцахуйн үр дүн нь хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай суралцахуйн амжилтыг тодорхойлох тусгай илэрхийлэл юм. Тухайлбал,

- Өргөн хүрээний концепцийн мэдлэг, тусгай болон ерөнхий чадварыг тусгадаг;
- Хамгийн чухал мэдлэг, чадвар, хандлагыг тусгадаг;
- Суралцахуйн туршлагын үр дүнд анхаарал хандуулах боломжийг өгдөг;
- Суралцахуйн туршлагын хүссэн үр дүнг тусгахаас биш үйл явцыг авч үзэхгүй;
- Хөтөлбөрийг судалж дуусгахад олж авсан байх ёстой минимум гүйцэтгэлийг үзүүлдэг.

Суралцахуйн үр дүнг боловсруулахдаа “ABCD” аргыг баримталсан болно. Энэхүү аргаар суралцахуйн үр дүнг дараах шаардлагыг баримталж боловсруулсан. Үүнд:

A	Сонсогч / Audience	Хэн	Суралцахуйн үр дүн хэнд хандсан бэ?
B	Төрх байдал / Behaviour	Юу	Сурагчид юуг мэддэг, чаддаг болно гэж хүлээж байна вэ? Идэвхтэй үйл үгээр илэрхийлнэ.
C	Нөхцөл / Condition	Хэрхэн	Ямар нөхцөлд байдал, хязгаарлалтад сургалтыг явуулах вэ?
D	Degree	Хэр зэрэг	Төрх байдлыг хэр зэрэг /хэр сайн/ ямар түвшинд гүйцэтгэсэн байх вэ?

Хөгжмийн суралцахуйн үр дүнг томъёолохдоо хичээлээр эзэмших чадварт суурилж агуулгаа багцалсан. Жишээ нь: Сурагч хөгжмийн хэлийг таньж мэдсэнээ, дуулж хөгжимдөж илэрхийлдэг болно.

Суралцахуйн үр дүнг нэгжийн агуулгыг судалсны дараа сурагч найдвартайгаар харуулж чадах хамгийн чухал, ач холбогдолтой суралцахуйг тооцож, SMART(TT) байхаар томъёолсон болно.

Суралцахуйн үр дүнг гүйцэтгэлийн төлөв байдлаар нь нэгтгэх замаар, өөрөөр хэлбэл, дуулах, хөгжимдөх, бүжиглэх гүйцэтгэлд суурилсан чадваруудыг нэгтгэж үр дүн болгосон. Харин сонсож танин мэдэх арга барил бүхий хичээлийн онцлогоо харгалзан хөгжим сонсох болон зохион найруулах үйлийг танин мэдэх, бүтээх түвшнээр ерөнхийд нь томъёолсон болно.

Суралцахуйн зорилт болоод суралцахуйн үр дүнгийн ялгааг авч үзвэл:

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
Оролт Чиглэсэн Зорилтын илэрхийлэл Мэдлэг чадварын тус тусдаа хэсгүүд Хөтөлбөр, удирдамжид тулгуурласан	Гаралт Бодитой Гүйцэтгэлийн түвшний нотолгоо Өргөн хүрээний мэдлэг, чадвар Хэрэглэх, өндөр түвшний суралцахуйд тулгуурласан
5.4.а. Хөгжмийн зохиолын төрөл зүйлийг /дуулаач, дан хөгжим/ сонсож тодорхойлох	Сурагч дуу, хөгжмийн бүтээлийн төрөл зүйлийг таньдаг болно.

### Г. Гүйцэтгэлийн үзүүлэлт боловсруулах

Үнэлгээний шалгуур гэж юу вэ? Энэ нь суралцагчийн ажлыг хэмжих жишиг стандартын цогц юм.

Үнэлгээний шалгуур нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг байна (Sadler, 1987). Үүнд:

- Шалгуур (criterion)
- Гүйцэтгэлийн үзүүлэлт (Achievement Standard, Performance Standard)

Шалгуур нь суралцагчийн хүрсэн үр дүн/амжилтыг нотлон харуулахад чиглэгдсэн суралцагчдын “Би юу хийх ёстой вэ?” гэдэг асуултад хариулагдана.

Гүйцэтгэлийн үзүүлэлт бол чанарын тодорхой түвшин (амжилт эсвэл гүйцэтгэл)-ийн тухай ойлголт бөгөөд “Би яаж хийх ёстой вэ?” гэдэгт хариулагдана. Жишээ нь: 4.1.3.1

Нэгж 3. Хөгжмийн энгийн хэлбэрүүд

СҮД-ийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
Хүүхдийн болон ардын дуу, аялгууг ноотоор дуулдаг.	Дуу аялгууны ноот бичлэгийн айзам хэмжээг ялган таньдаг	Ноот бичлэг дэх тэмдэг тэмдэглэгээний үүргийг тайлбарладаг	Ноот бичлэгээс хүндрэлтэй хэсгийг олж чаддаг.	Хүүхдийн болон ардын дууг ноотоор дуулдаг.

Хичээлийн онцлогтой холбоотойгоор задлан шинжлэх, үнэлэлт дүгнэлт өгөх, бүтээх үйлийн шалгуураар гүйцэтгэлийг үнэлэх бүрэн боломжтой. Жишээ нь: Өөрийн болон бусдын гүйцэтгэлийн үр чадварт үнэлэлт дүгнэлт өгөх, алдааг олж илрүүлэх, санаа бодлоо илэрхийлэх, сонссон хөгжмийн бүтээлийн санаа амьдралын ямар дүр байдлыг илэрхийлж, ямар сургамж өгч байгааг уялдаа холбоонд нь тайлбарлах гэх мэт шалгууруудыг үр дүн болгон томъёолсон байгаа. Мөн СҮД-ээс шалгуураа томъёолохдоо сургалтын хөтөлбөрийн үнэлгээний шалгуураа баримжаалсан.

Блумын шинэчилсэн таксономид 19 когнитив үйлийг 6 түвшинд ангилсан ангилал, үнэлгээний журмын шалгуурыг баримжаалж, тэдгээрийн онцлог, харилцан холбоог судалсны үндсэн дээр гүйцэтгэлийн хүрэх түвшинг боловсруулж гаргасан.

### Д. Жилийн суралцахуйн үр дүнг тодорхойлох

Жилийн суралцахуйн үр дүнг хөгжмийн хичээлээр сурагчдын хүрсэн байх мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхээр томъёолсон. Ер нь шалгуурт суурилсан үнэлгээ нь суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэдгийг багш нар сайн ойлгох хэрэгтэй.

Суралцахуйн үр дүнг хөгжмийн хичээлийн жилийн төлөвлөлтөд тусгаж, үр дүнгийн үнэлгээнд хэрэглэх жишээг (5-р анги) дараах байдлаар боловсруулан хүргэж байна.

Улирал	1-р улирал																2-р улирал								3-р улирал						Нийт цаг																																			
	IX					X					XI						II				III				IV							V		VI																																
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30		31	32	33																																
Бүлэг сэдэв	Аялгуу								Хөг эгшиглэгээ								Хэлбэр								Хөгжмийн хэл																																									
Суралцахуйн зорилт	5.1.а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг (AB, ABA, ABC, A1A2A3) тодорхойлох, ялган таних					5.1.б. Диатоник, пентатоник мажор, минорын ладад дуулж ялгааг тайлбарлах					5.1.в. Утга санаа илэрхийлж уран яруу /нэвцэн/ гоцлол болон найрал хэлбэрээр хоёр хоолойгоор хөгжимдэх					5.1.г. Тодорхой сэдвийн (галт тэрэг, уралдаан, бүүвэй гэх мэт) дагуу хэмнэлийн зохиомж гүйцэтгэх					5.2.а. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг /пентатоник, диатоник/ сонсож тодорхойлох					5.2.б. Эгшиг зохиолроор /консонанс, диссонанс интерваг/ дуулж онцлогийг тайлбарлах					5.2.в. Бүжгийн энгийн элемент бүхий дасгалыг гүйцэтгэх					5.2.г. Хөгжмийн энгийн зэмсгүүдийг ашиглан цохивоор хөгжмийн найруулгыг жишээгээр харуулах					5.3.а. Эгшиг зохиолыг /консонанс, диссонанс интерваг / сонсож таних				5.3.б. Ноот бичлэгийг харж канон, имитаци хэлбэрийг тайлбарлан дуулж хөгжимдэх				5.3.в. Хөгжмийн зохиолын агуулга дүрийг гоцлол цөхүү хэлбэрээр хөдөлгөөнөөр илэрхийлэх				5.3.г. Өгөгдсөн аялгууг хөгжүүлэх, хувилбарлах.		5.4.б. Удирдаачийн дохисоор хурд, хүчний өөрчлөлтийг илэрхийлж гоцлол найрал хэлбэрээр дуулах, хөгжимдэх						5.4.в. Хөгжим болон хөдөлгөөний уялдаа холбоог тайлбарлах.		5.4.г. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг янз бүрийн арга хэлбэрээр /өнгө будаг, зураглал/ илэрхийлэх		5.4.д. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг янз бүрийн арга хэлбэрээр /өнгө будаг, зураглал/ илэрхийлэх	
Цаг	2	2	3	2	2	2	2	2	2	2	1	2	3	2	1	2	3	2	1	2	3	2	2	2	3	2	2	2	2	2	2	2	2																																	
Суралцахуйн үр дүн	Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрүүдийг танидаг болно. Эгшиглэгээний ялгааг сонсож танидаг, дуулж илэрхийлдэг болно. Гоцлож болон хамтран дуулж, хөгжимдэж чаддаг болно					Хөгжмийн бүтээлийн эгшиглэгээний онцлогийг тодорхойлдог					Эгшиглэгээний онцлогийг мэдэрч дуулж хөгжимддэг болно. Аялгууны шинж төрхийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулдаг болно					Хөгжмийн энгийн зэмсэг бүтээж, хэмнэлийн хамсраа хийж хөгжимддэг болно					Эгшиг дуурьсалын онцлогийг сонсож танидаг болно. Гоцлож болон хамтран ноотоор дуулж, хөгжимддэг болно. Хөгжмөөс төрсөн мэдрэмжээ хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно. Өөрийн мэдрэмж, санаагаа дуу, хөгжим, хөдөлгөөнөөр илэрхийлэх арга барилтай болно.								Дуу, хөгжмийн бүтээлийн төрөл зүйлийг танидаг болно						Хөгжмийн хэлийг таних мэдсэнээ, дуулж хөгжимдэж илэрхийлж чаддаг болно. Хөгжмөөс төрсөн мэдрэмжээ илэрхийлж бүжиглэж чаддаг болно. Хөгжмөөс төрсөн сэтгэгдлээ илэрхийлж чаддаг болно.																															
Үнэлэх хэлбэр	Явцын																																																																	
	Бичиг																																																																	
	Ам																																																																	
	Бие даалт																																																																	
ХШ																																																																		
Бүлэг сэдвийн үнэлгээ																																																																		

Багш та энэхүү зөвлөмжийг “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж” БХ, (2020)-д тусгагдсан “Үр дүнгийн оношилгоо, эргэх холбоо тогтоох аргачлал” хэсгийн сурагчийн бүтээлийг үнэлэх олон төрлийн рубрик, өөрийн үнэлгээний арга хэрэгсэл, оношлох даалгавар, шинжилгээ хийх, сурагчдын дутуу, ташаа мэдлэг, ойлголтыг оношилж, үр дүнд шинжилгээ хийх аргачлалтай хамтатган хэрэглэхийг зөвлөж байна.

Үүнээс гадна хөгжмийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурт ашигласан нэр томъёог нэгэн утгаар ойлгож ашиглах нь чухал юм. Ингэснээр шалгуурыг зөв ойлгож үнэлгээний даалгаврыг боловсруулах, сурагчдыг шударга үнэлэх боломжтой. Мөн даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийж, сурагчдад дэмжлэг үзүүлэх, хичээлийн төлөвлөлт, хэрэглэгдэхүүн зэргийг сайжруулахад тустай. Шалгуурт ашигласан нэр томъёог тодорхойлохдоо хөгжмийн үндэсний хөтөлбөр болон монгол хэлний тайлбар толь бичиг зэрэг бусад эх сурвалжийг ашигласан болно.

Нэр томъёо	Тодорхойлолт
Ангилал	Суралцагч ямар нэг зүйл (тухайн тохиолдол, жишээ)-ийг юу (ойлголт, зарчим)-нд хамаарахыг тодорхойлох, мөн харгалзах өвөрмөц онцлог (эсвэл хэв загвар)-ыг тодорхой тохиолдол, ойлголт, эсвэл зарчимд нь таацуулах үйл хийж байвал түүнийг ангилах үйл хийж байна гэж үзнэ.
Байр суурь	Байр суурь нь хүн, эсхүл хэсэг бүлгийн нас, хүйс, туршлага, шашин соёлын угсаа гарал, итгэл үнэмшил болон оюуны чадавх зэргээс шалтгаалах бөгөөд тэдний ертөнцийг үзэх үзэл бодол, үнэ цэн, үйлдлийг тодорхойлж байдаг. Байр суурийн хоёр хэлбэр байна. Үүнд: Хүмүүсийн үзэл бодол, байр суурь Өнгөрсөн болон одоо үеийн үйл явдал, үзэгдлийг харах байр суурь
Боловсруулах	Өгөгдсөн асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэх үйлийг дэлгэрүүлж, өргөжүүлж нарийвчлах үйл явц
Бүтээх	Элементүүдийг хооронд нь дотоод уялдаа холбоогоор нь нэгэн бүхэл хэлбэрт оруулахыг бүтээх гэнэ. Бүтээхтэй холбоотой үйл нь ерөнхийдөө тухайн суралцагчийн чадвар, өмнөх туршлагатай холбоотой байх ба суралцагчдаас бүтээлч сэтгэхүйг шаарддаг.

Гүйцэтгэх	Суралцагчид танил даалгаврыг сайн мэдэх үйлдлийн дагуу хийж байгаа үйл
Дараалалд оруулах	Тодорхой дараалалд оруулах. Он цаг, үйл явдал, хэмнэл зэргийг дараалалд оруулах багтана.
Жишээгээр харуулах, гаргах	Суралцагч оновчтой жишээ гаргаж, эсвэл ерөнхий ойлголт, зарчмын тодорхой тохиолдлыг нэрлэж байвал “жишээ гаргах” гэж үзнэ.
Зураглах	Асуудлыг төсөөлөн дүрслэх схемчлэх, багцлал үүсгэх
Илтгэх	Тодорхой сэдвээр мэдээлэх, тодорхой сэдвийг хөндөх, ялангуяа дүрс, зураг, цахим дата, үзүүлэн гэх мэтээр баяжуулсан байх.
Мэдээлэл	Зарим баримт, нөхцөл байдлын талаар солилцож, хүлээн авч буй мэдлэг
Сайжруулах	Чанарыг сайжруулах, эсхүл илүү тодорхой болгох үүднээс өөрчлөлт хийх, хувиргах, зохилдуулах
Тодорхойлох	Үйл явдал, тэдгээрийн шинж чанар, шинж тэмдгийг дүрслэх
Тайлбарлах, тайлбар	Хөгжмийн уран бүтээлийг өөрийнхөөрөө тайлбарлах, жишээгээр тайлбарлах, бүтээлийн үйл явдал, өрнөлийг тайлбарлах.
Тунгаан шийдэх	Нотолгоо, шийдвэрийг яагаад гаргах болсон учир шалтгааныг харуулах, учир шалтгааныг нотлох баримтыг оновчтой харуулах
Учир шалтгаан, үр дагавар	Цаг хугацааны туршид, богино болон урт хугацааны туршид үйл явдлын хэлхээ, гинжин өрнөлийг тогтооход хэрэглэх
Учирлан тайлбарлах	Суралцагч шалтгаан-үр дагавар гэсэн загварыг бүтээх болон ашиглаж байвал тайлбар өгөх үйл хийгдэж байна.
Үр өгөөжтэй	Хүссэн үр дүнд хүрэхийн тулд үр өгөөжтэй эсхүл нарийн тунгаасан байдлаар даалгаврын зорилтыг биелүүлэх
Үйл явц	Тодорхой арга аргачлалын дагуу бэлтгэх, сайжруулах; хоорондоо харилцан уялдаатай, ахисан (progressive) байдлаар явагдаж буй, төгсөх, дуусах руу чиглэсэн алхмууд
Үнэлэх	Үнэлэх гэдэг нь шалгуур ба стандартад үндэслэн шүүж, дүгнэх үйл юм.
Оновчтой	Нарийвчилсан, тодорхой, стандарт, дүрэм, журам болон бусад баримтын дагуу, бүх талаар зөв байх
Ойлгох	Суралцагч ном, компьютероос аман, бичгийн, график гэх мэт харилцааны бүхий л хэлбэрээр өгч буй мэдээллийг өөртөө тодорхой утгатай, бүтэцтэй болгон бүтээхийг хэлнэ.
Хөгжмийн хэл, ухагдахуун	Хөгжмийн онолын нэр томъёог илэрхийлсэн үг, хэллэг
Харьцуулах	Хоёр ба түүнээс дээш юмс, үйл явдал, бодол санаа, асуудал, эсвэл аливаа зүйлсийн ялгаатай болон ижил төстэй байдлыг илрүүлэх, хэмжих, тэмдэглэх
Хэрэглэх	Ашиглах, хэргийг нь гаргах? Дасгал гүйцэтгэх, асуудал шийдвэрлэхэд тодорхой аргачлалыг хэрэглэхийг хэлнэ.
Холбогдолтой, нийцтэй	Логик уялдаа холбоотой, хамааралтай
Шинжлэн судлах	Тухайн уран бүтээлийн үйл явдлыг ойлгох зорилгоор хийж буй судлах үйл явц. Үүнд, асуулт асуух, эх сурвалжийг олж илрүүлэн, анализ хийх, баримт нотолгоонд суурилан өнгөрсөн үеийн талаар мэдээлэлд суурилсан тайлбар боловсруулах
Шинжилгээ хийх	Утга учир, уялдаа холбоог олж тогтоох, зүй тогтол, адил болон ялгаатай талыг илрүүлэхийн тулд бүх талыг нарийвчлан харгалзаж үзэх
Эх/текст	Харилцаа холбооны нэг хэрэгсэл. Эхийн тогтсон хэлбэр, хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь бидэнд янз бүрийн зорилгоор, янз бүрийн хүлээн авагчтай үр өгөөжтэйгөөр холбоо харилцаа тогтоож, харилцахад тусалж иржээ. Эх нь амаар, бичгээр, хосолсон, хэвлэмэл эсхүл цахим хэлбэрээр байж болно. Хосолсон эх нь хэлийг харилцаа холбооны бусад системүүдтэй (хэвлэмэл, харагдах дүрс, дуу эгшиг, хэлсэн үг, хальс эсхүл компьютер дээр буулгасан медиа) холбосон байдлыг хэлнэ.
Ялган таних	Бүх талыг нь харгалзсан сонголт хийхийн тулд сайтар тунгаан бодсон байх

## Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

Гүйцэтгэлийн үнэлгээгээр “хэн нь илүү сайн байсныг үнэлэх” биш, харин “сурагч ямар амжилтад хэр хэмжээнд хүрснийг” үнэлдэг. Өөрөөр хэлбэл, сурах-сургах явцад сурагчид гарсан өөрчлөлт, өсөлтийн талаарх материалыг цуглуулж тохирсон зөвлөгөө өгч ажиллах юм. Үнэлэх үйл ажиллагаа нь дараах дарааллын дагуу хэрэгждэг байна. Тухайлбал,

Үйл ажиллагаа	Агуулга	
Гүйцэтгэлийн шалгуурыг шинжлэх, үнэлгээний төлөвлөгөө боловсруулах	<ul style="list-style-type: none"> <li>– Сургалтын хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуурт дүн шинжилгээ хийж, үнэлгээний элементийг сонгох</li> <li>– Улирлын нэгжээр үнэлгээний төлөвлөгөө гаргах</li> </ul>	
Даалгавар боловсруулах төлөвлөгөө (блюпринт) гаргах	Бичгийн шалгалтын даалгаврын мэдээллийн хүснэгт гаргах	Гүйцэтгэлийн үнэлгээний даалгавар боловсруулах төлөвлөгөө гаргах
Үнэлгээний хэрэгсэл боловсруулах	Бичгийн шалгалт	Гүйцэтгэлийн үнэлгээ
	<ul style="list-style-type: none"> <li>– Сонгох хэлбэрийн даалгавар</li> <li>– Задгай хэлбэрийн даалгавар, дүгнэх шалгуур боловсруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Гүйцэтгэлийн үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулах</li> <li>– Гүйцэтгэлийн үнэлгээний даалгавар, дүгнэх шалгуур боловсруулах</li> </ul>
Үнэлж дүгнэх	<ul style="list-style-type: none"> <li>– Гүйцэтгэлийн шалгуурын дагуу сурагч бүрийн гүйцэтгэлийн түвшин болон суралцах, гүйцэтгэх явцыг үнэлэх</li> <li>– Сургалтын хөтөлбөрөөс гадуур гүйцэтгэлийн үнэлгээ хийхийг хориглох</li> </ul>	
Үнэлгээний үр дүнг шинжлэх, зөвлөгөө өгөх	<ul style="list-style-type: none"> <li>– Үнэлгээний үр дүнг шинжилж сурагч тус бүрт гаргасан амжилтын түвшингийг нь дагуу зөвлөгөө өгөх</li> <li>– Гүйцэтгэлийн үнэлгээ хийсэн бол явцын талаарх зөвлөгөө өгөх</li> <li>– Сурагчийн сургалтын зорилтод хүрсэн түвшинг шалгаад сурах-сургахуйг сайжруулахад ашиглах</li> </ul>	
Үнэлгээний үр дүнг боловсруулах	Улирлын эцэст хичээлийн дүнг боловсруулж, хувийн хэрэгт бичих	

### Даалгавар гэж юу вэ?

Я.Цэвэл (1966) толь бичигт “даалгавар”-ыг гүйцэтгүүлэхээр өгсөн үүрэг гэж тайлбарласан байдаг. Монгол хэлний товч тайлбар тольд “Сурагч гэрийн даалгавар хийх, дасгал ажиллах, гэртээ хийх дасгал ажил”-ыг даалгавар хэмээн тайлбарласан байна.

Суралцагчдын ангид болон гэрт гүйцэтгэх даалгавар нь тэдний бие дааж ажиллаж сурах цаашилбал өмнөө тавьсан зорилгодоо хүрэх, суралцах үйлдээ ухамсартай мэдрэмжтэй өөрийн гэсэн бодолтой хандах чадвар төлөвшихөд нөлөөлөх гол хүчин зүйл юм.


Даалгаврын гол үүрэг зориулалт нь хүүхдээр танин мэдэхүйн тодорхой үйлүүд хийлгэх түүнийг гүйцэтгэх явцад тэдэнд тохиолдсон бэрхшээл дээр ажиллахад чиглэдэг. Тухайлбал,

1. Сурагч бүтээсэн мэдлэгээ ашиглах, хэрэглэх түвшинд ажиллах
2. Мэдлэг, төсөөллөө гүнзгийрүүлэх
3. Сурах хөдөлмөрөө зохион байгуулах эмх цэгц, дэг журамд суралцах
4. Зорилготой, итгэл үнэмшилтэй, аливаад тэвчээртэй, хүсэл тэмүүлэлтэй болж төлөвших
5. Сурч боловсроход биеэ дайчилж, сурах арга барилтай болох зэрэг нөлөөлнө.

Даалгавар хэдий чинээ тодорхой байна төдий чинээ хялбар, бүтээлч, хөгжүүлэхүйц шинжтэй болдог. Тухайлбал уншсаны дараа өгөх асуулт-даалгавар дараах байдалтай байж болно.

1. Юуны тухай уншив?
2. Гол санаа нь юу вэ?
3. Өмнө нь энэ талаар ямар нэг ойлголттой байв уу?
4. Чиний ойлголтоос хэр зэрэг зөрөөтэй байна вэ?
5. Одоо юу гэж ойлгов?
6. Ойлголт төсөөллөө өөрийн үгээр илэрхийлнэ үү? гэх зэргээр багш асуултаа дэвшүүлэх нь сурагчдын ярих, бодож сэтгэх асуултад оновчтой хариулж сурахад тусална.

Хөгжмийн хичээлийг даалгаварт суурилсан арга зүйгээр зохион байгуулж суралцахуйн зорилтыг үнэлж болно. Үүний тулд даалгаврын төрөл ямар байх вэ? гэдэгт анхаарлаа хандуулна. Тухайлбал,



Даалгавар нь танин мэдэхүйн ямар түвшнийх байх вэ?

1. Сэргээн санах түвшин
2. Ойлгох түвшин
3. Задлан шинжлэх түвшин
4. Хэрэглэх түвшин
5. Үнэлэх түвшин
6. Бүтээх түвшин

Даалгаврын хэлбэр ямар байх вэ?

Сонсох, дуулах, хөгжимдөх (гүйцэтгэлийн ур чадвар), анализ хийх, тодорхойлох, нэрлэх, тайлбарлах, нэгтгэн дүгнэх, үнэлэлт өгөх, баталж нотлох, нөхөх гэх мэт

Даалгаврыг дараах алхмын хүрээнд боловсруулна. Үүнд:

- Хураангуй блюпринт хийх
- Дэлгэрэнгүй блюпринт хийх
- Даалгавар бүрийн дэлгэрэнгүй мэдээллийн матриц гаргах
- Даалгавар боловсруулах



Үнэлгээний даалгаварт тавигдах шаардлага

- Үнэлгээний даалгавар нь явцын ба эцсийн үнэлгээний зарчмыг хангах (хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцсэн)
- Сургалтын хөтөлбөрийн агуулгад үндэслэсэн байх
- Тохирцтой байх
- Бодитой, хэмжигдэхүйц (хэмжих шалгууртай) байх
- Суралцагчдын гүйцэтгэлд суурилсан байх
- Үнэлгээний даалгавар нь олон төрөлтэй, мэдээллийн олон хэлбэрийг багтаасан байх
- Танин мэдэхүйн ач холбогдолтой байх

*Эх сурвалж: Нэнси П.Галлаван “Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ боловсруулах нь”*

Олон сонголтот даалгавар

Шалгуулагч өгөгдсөн хариултын хувилбаруудаас хамгийн зөв хариултыг сонгох хэлбэрийн даалгаврыг олон сонголттой даалгавар гэдэг. Олон сонголттой даалгаврын давуу болон сул талыг авч үзвэл:

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>– Үнэлгээний бүх зорилтын хүрээнд даалгавар боловсруулах, суралцагчдын мэдлэг, чадварыг шалгах</li> <li>– Тестийн найдвартай байдал өндөр</li> <li>– Шалгалтын материалыг хурдан засах</li> <li>– Богино хугацаанд гүйцэтгэх</li> <li>– Эсээ хэлбэрийн даалгаварт хариулах хугацаанд хэд хэдэн олон сонголттой даалгаварт хариулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Суралцагчийн унших чадвар болон багшийн бичих ур чадвараас их хамааралтай байдаг.</li> <li>– Даалгавар зохиоход цаг хугацаа их шаардагддаг, боловсруулахад төвөгтэй байна.</li> <li>– Сурагчаас бичих чадвар бага шаардана.</li> <li>– Тааж хариулах магадлалтай байдаг.</li> </ul>

Олон сонголтот даалгавар боловсруулахдаа дараах шалгуурыг баримтлах хэрэгтэй. Үүнд:

#### Шалгуур

Асуулт	Тодорхой нэг зорилготой байх
	Тодорхой томъёологдсон асуултад суурилсан байх
	Асуулт нь хамааралгүй материал агуулаагүй байх
	Эерэг хэлбэрийн асуулт тавих
Хариултын хувилбар	Хариултын хувилбаруудыг товч, тодорхой үгээр илэрхийлэх
	Харилцан тусгай сонголтуудыг авах
	Агуулгын хувьд хувилбаруудыг нэгэн төрлийн байлгах
	Зөв хариулт бүхий сэжмээс хувилбаруудаа хамгаалах
Зөв хариу	“Дээрх бүгд зөв”, “дээрхийн аль нь ч биш” гэсэн хувилбаруудаас зайлсхийх
	Үүрэгтэй буруу хариултыг хэрэглэх
	Цорын ганц зөв эсвэл гарцаагүй хамгийн сайн хариулт агуулах
	Зөв хариулт нь санамсаргүй дараалалд байрласан байх
Даалгавар	Даалгавруудыг тодорхой дараалсан байдлаар тараах
	Тохирсон хэлзүй, цэг, таслал, тэмдэг ашиглах
	Хүнд үг ашиглахаас зайлсхийх

Жишээлбэл:

1. Гурвуулаа зөв байх хувилбарыг олно уу?

- |            |  |
|------------|--|
| 1. Увертюр | А. Хөгжимчний ур чадварыг хөгжүүлэхэд зориулсан. |
| 2. Этюд    | Б. Дараалал гэсэн утгатай, олон хэсэгтэй.        |
| 3. Сюит    | В. Зохиолын агуулгыг хураангуйлсан эхлэл хөгжим  |

А. 1В 2А 3Б

Б. 1А 2В 3Б

В. 1Б 2А 3В



Даалгавар. Аль хэмнэлийг тоглосон бэ ? Тогшиж үзээд зөвийг сонгоно уу?



1. Даалгаврыг алхамчлан задлан шинжлэх

Сургалтын хөтөлбөр, агуулгын залгамж холбооны дагуу даалгаврыг шинжилж үзэхэд:



Агуулгын залгамж холбооноос харахад 1-р ангид “энгийн хэмнэл”-ээр эхэлж байгаа. 3-р ангид “цэгтэй” болон “догол” хэмнэл, зогсоц үзсэн. 4-р ангид “ноот бичвэр”-ийг уншиж айзам хэмжээг тогтоох, 5-р ангид “ноот бичвэрийг хараад дуулж, хөгжимдөх”-өөр байгаа.

2. Ямар чадварыг шалгаж буй даалгавар вэ?

Зөв хариуг “хэмнэл” /1-р анги/, “ноотны задаргаа”-г /2-р анги/, “зогсоц” /3-р анги/-ын тухай “мэдэж байгаа” /мэдлэг/ бол сонгож чадна.

3. Буруу хариултын шинжилгээ

Даалгаврын дугаар	Хариултын хувилбарын төрөл	Гүйцэтгэл	Зөв хариулт
1	A	17%	
	B	21.4%	
	C	47.7%	✓
	D	11.8%	

Энэ даалгавар нь аялгууг сонсоод хэмнэлийг тодорхойлох даалгавар бөгөөд гүйцэтгэл нь 47.7 хувь байна. Суралцагчдын хариулсан байдлыг авч үзвэл А хариултыг 45.0 хувь, В хариултыг 19.1 хувь, С хариултыг 18.1 хувь, D хариултыг 12.8 хувь тус тус сонгосон байна. Буруу хариулсан байдлаас сурагчдын алдаж байгаа хэсгийг сайтар анхаарч үзвэл юуг ойлгоогүй байна вэ гэдэг нь тодорхой харагдана. Тухайлбал, хэмнэлийг сонсож мэдрээгүй – 17%, дөрөвт наймт ноотны тухай ойлголтгүй – 21.4%, зогсоцын тухай ойлголтгүй – 11.8% байна.

Даалгаврын өгөгдлийг харахад дөрөвт, наймт ноот бүхий хэмнэл нь маш энгийн, III ангийн сурагчдын хувьд хялбар даалгавар. Гэлээ ч гүйцэтгэл сул байгаа нь багш нар сурагчдын сонголын ойг хөгжүүлэх, ноот уншиж хэмнэлээр хөгжимдөх үйл ажиллагааг түлхүү явуулах шаардлагатайг харуулж байна. Ноотны дүрсийг харах, ялгааг таних, үүргийг мэдэх, тайлж унших, гүйцэтгэлээр харуулах зэрэг зорилтод чиглэсэн даалгавруудаар хөтлөн ажиллахыг зөвлөж байна.

#### 4. Эргэх холбоо

Буруу хариултын шинжилгээгээр илрүүлсэн хүүхдүүдийн алдаж буй асуудлыг тэр чигт нь орхиж болохгүй. Тиймээс та болон тантай хамт ажиллаж буй бусад багш нар хамтран энэ хэсгийг заахдаа өөрөөр бодож, өөр аргаар заахгүй бол хүүхдүүд өмнөхтэй ижил алдаа гаргах нь дамжиггүй. Иймд хүүхдэд дэмжлэг үзүүлэхээс гадна ирэх жил энэ агуулгыг заахад багшид зориулан сайжруулах саналыг бодож боловсруулах хэрэгтэй юм.

*Эргэх холбоо 1: Хүүхдэд чиглэсэн эргэх холбоо /фийдбак/*

Даалгаврын явцад илэрсэн гол асуудал нь “зогсоц”-ын тухай ойлголтгүй байгаа явдал юм. Иймд хүүхдэд тэр талаар нэмэлтээр тайлбар өгч дасгал ажиллуулж болно.

*Эргэх холбоо 2: Багш нар харилцан суралцах*

Таны хичээл дээр тулгарч байгаа асуудлууд бусад багш нарт ч мөн тулгарч байх магадлал өндөр байдаг. Иймд “Хичээлийн санаа”-г ашиглан шинэ аргаар заахыг санал болгож болно.

Суралцахуй нь сурах үйлийг тасралтгүй үргэлжлүүлж хийснээр сайжирна. Үелсэн /спирал/ хэлбэрээр суралцсанаар хүүхдэд хэрэглэгдэх мэдлэг бий болдог. Өөрөөр хэлбэл, сурлагын амжилтыг үнэлэх нь үелсэн агуулгын аль хэсэгт “алдаж” байгааг илрүүлэхэд дэмжлэг болох юм.

Тухайн ангид эзэмшсэн мэдлэгийг үнэлэхийн тулд доорх зүйлсийг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Үүнд:

Агуулгын аль хүрээ 2. Аль нэгж хичээл 3. Аль сэдэв (Өмнө үзсэн аль сэдэв) 4. Үнэлэх гэж буй чадвар нь аль вэ? (мэдлэг ойлголт, хэрэглээ, асуудал шийдвэрлэх чадвар, шинжилгээ, үнэлгээ), эргэх холбоо. Жишээ нь:

**1. Асуудлыг шинжлэх**

Шинжлэхээр зорьж буй асуудал бүрийг алхамчлан бичнэ.

**2. Ямар чадвар**

Өмнөх мэдлэг

Чадвар

Мэдлэг/ойлголт       Хэрэглээ

Дүн шинжилгээ       Гүйцэтгэл

**3. Буруу хариултын шинжилгээ**

Даалгаврын дугаар	Хариултын хувилбарын төрөл	Гүйцэтгэл	Зөв хариулт
	A	%	
	B	%	
	C	%	
	D	%	

**4. Эргэх**

Хичээлээ хэрхэн заавал сурагчдын алдаатай ойлголт багасах вэ?

Хичээлийн шинэ санаа гаргах

**Бага боловсролын “Хэлбэр” нэгжийн хүрээнд хийсэн үнэлгээний аргачалалтай танилцъя.**

Сургалтын хөтөлбөр дэх үнэлгээний зорилт, шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт	А1. Урлагийн хэл, нэр томьёо
Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар	Б1. Зурах, дүрслэх, зохион бүтээх ур чадварын гүйцэтгэл Б2. Сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх ур чадварын гүйцэтгэл
В. Хандлага*	В1. Урлагийн бүтээлд хандах хандлага, хүсэл сонирхол В2. Урлагийн олон талт үйл ажиллагаанд оролцох оролцоо, идэвх, зүтгэл

\*Сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

Үнэлгээний зорилтод харгалзах оноо (жин)

Үнэлгээний зорилт				Нийт оноо
Мэдлэг ойлголт	Гүйцэтгэх чадварын ахиц	Бүтээлчээр хөгжих чадвар	Судлах хүсэл, сонирхол, хандлага	10
40%	20%	20%	20%	100%

**“Хэлбэр” нэгжийн төлөвлөлтийн жишээ:**

Зорилго: Эгшиг дуурьслын онцлогийг тайлбарлаж чаддаг болно.

Зорилт:

- Хөгжмийн уран бүтээлийг сонсоод эгшиг дуурьслын онцлогийг тайлбарлах
- Гоцлол болон хамтран канон хэлбэрт ноотоор дуулж, хөгжимдөх
- Хөгжмөөс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ хөдөлгөөнөөр илэрхийлэх

Агуулгын залгамж холбоо:

Агуулга /Суралцахуйн зорилт/		
Өмнө судласан агуулга	Одоо судлах агуулга	Дараа судлах агуулга
Хөг эгшиглэгээ – Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг /пентатоник, диатоник/ сонсож тодорхойлох – Эгшиг зохирлоор /консонанс, диасонанс/ дуулж онцлогийг тайлбарлах	Хэлбэр – Эгшиг зохирлыг /консонанс, диссонанс/ сонсож таних – Ноот бичлэгийг харж канон, имитаци хэлбэрийг тайлбарлан дуулж, хөгжимдөх	Хөгжмийн хэл – Хөгжмийн зохиолын төрөл зүйлийг /дуулаач, дан хөгжим/ сонсож тодорхойлох – Удирдаачийн дохиогоор хурд хүчний өөрчлөлтийг илэрхийлж гоцлол, найрал хэлбэрээр дуулах, хөгжимдөх

## Төлөвлөлт

Суралцахуйн зорилт	Ээлжит хичээлийн зорилго	Цаг	Хэрэглэгдэхүүн	Үнэлгээний зорилт			Үнэлгээний шалгуур
				I	II	III	
5.3.а. Эгшиг зохирлыг /консонанс, диссонанс/ сонсож таних	Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг сонсож таних, харьцуулах	2	К. Сенсанс “Амьтдын марш” зохиолын “Заан” И. Чайковский “Цөмөөхэй” бүжгэн жүжгийн “Хятад бүжиг”				Хөгжмийн зохиолыг сонсоод эгшиглэгээний онцлогийг тайлбарладаг.
5.3.б. Ноот бичлэгийг харж канон, имитаци хэлбэрийг тайлбарлан дуулж, хөгжимдөх	1. Ноот бичлэгийг харж канон, имитаци хэлбэрээр дуулах 2. Дууны ноот бичлэгийг ажиглаад канон, имитаци хэлбэрээр хөгжимдөх 3. Өгөгдсөн размерт канон хэлбэрээр зохион найруулах	3	“E gam sam sam”				Канон, имитаци хэлбэрт гоцлол, цөөхүүлээр дуулдаг Гоцлол, цөөхүүлээр янз бүрийн хэлбэрт хөгжимддөг.
5.3.в. Хөгжмийн зохиолын агуулга дүрийг хөдөлгөөнөөр илэрхийлэх	Аялгууны хэмнэлд тохируулан утга санааг илэрхийлж бүжиглэх	2	“Ёохор” тойрон бүжиг “Полька” тойрон бүжиг				Хөгжмийн бүтээлийн утга санаа, дүрийг илэрхийлэн бүжиглэж чаддаг болно.
5.3.г. Өгөгдсөн аялгууг хөгжүүлэх, хувилбарлах	Өгөгдсөн аялгуу болон хэмнэлийг зохиомжлох, хувилбарлах, хөгжүүлэх.	1	4 2 4 3 4 4 размер тараах материал				Өгөгдсөн хэмд аялгууг хөгжүүлэн зохиомжилдог.

Нэгж хичээлийн төлөвлөлтөд агуулгын залгамж холбоог гаргаж ашиглаж байх хэрэгтэй. Энэ нь нэгж хичээлийн төлөвлөгөө боловсруулахад “Энэ нэгж хичээл хүртэл юу сурав?”, “Энэ нэгж хичээлийн дараа юу сурах вэ?” гэдгийг шууд мэдэх боломжтой байдаг.

Мөн бусад судлагдахууны агуулгын залгамж холбоог ашигласнаар судлагдахуун хоорондын хөндлөн холбоог харж хийгдэх үйл ажиллагааны талаар хэлэлцэхэд хялбар болно.

**“Хэлбэр” нэгжийн үнэлгээний нарийвчилсан төлөвлөгөө** (Блюпринт)

Блюпринт гэдэг нь тухайн шалгалтын даалгаврын талаарх бүх мэдээллийг багтаасан нэгтгэл юм.

Агуулга (Суралцахуйн зорилт)	Даалгаврын дугаар	Даалгаврын хэлбэр	Танин мэдэхүйн түвшин						Үнэлгээний зорилт				Зөв хариулт	Оноо	
			Сэргээн санах	Ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх сонсголын анализ)	Үнэлэх	Бүтээх	Мэдлэг ойлголт	Гүйцэтгэх чадварын ахиц	Бүтээлчээр хөгжих чадвар	Судлах хүсэл, сонирхол, хандлага			
5.3.а. 5.3.б. 5.3.в. 5.3.г.	1	Сонгох	1						1						
	2	Сонгох	1						1						
	3	Сонгох		1					1						
	4	Сонгох			1				1	1	1				
	5	Сонгох			1				1	1		1			
	6	Сонгох	1						1						
	7	Сонгох		1					1						
	8	Сонгох			1				1	1					
	9	Сонгох			1				1	1					
	10	Сонгох		1					1	1					
	11	Задгай	1						1						
	12	Задгай				1			1	1	1				
	13	Задгай					1		1	1	1				
	14	Задгай			1				1	1	1	1			
	15	Задгай						1	1	1	1	1			

Дээрх төлөвлөлтийн дагуу боловсруулсан үнэлгээний даалгаврын жишээ:

### Сонгох даалгавар

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
5.3.а Эгшиг зохирлыг /консонанс, диссонанс/ сонсож таних.	Хөгжмийн бүтээлийн эгшиглэгээний онцлогийг тодорхойлох	Хөгжмийн зохиолыг сонсоод эгшиглэгээний онцлогийг тайлбарлана.

#### Сэргээн санах түвшин

- Сонсоход тааламжтай, нийцтэй эгшиглэгээг юу гэж нэрлэдэг вэ?  
А. Диссонанс      Б. Консонанс      В. Септима
- Эгшгийг хагас өнгөөр доошлуулах үүрэгтэй тэмдгийг олж дугуйлаарай.  
А. ♭      Б. ъ      В. #      Г. ♮      Д. ##



#### Ойлгох түвшин

- Дэвсгэр шугамд Ре, Фа диез, Ля эгшгүүдийг тэмдэглэсэн тэмдэглэгээний аль нь зөв бэ?




**Хэрэглэх түвшин**

4. Дараах ноот бичлэг дэх эгшгүүдийг нэрлэж бичээрэй.


A.  Б.  В.  Г. 

.....

Б. Нэрлэж бичсэн эгшгээ төгөлдөр хуурын даралт дээр тэмдэглээрэй.



В. Тэмдэглэсэн эгшгүүдийг тоглоход хэрхэн сонсогдож байна вэ? Сонсоход тааламжтай бус, нийцгүй эсвэл тааламжтай нийцтэй байгааг нь тодорхойлж бичнэ үү.

A.  Б.  В.  Г. 

A..... Б..... В..... Г.....

5. Дараах эгшгүүдийг даралтат хөгжим дээр байрлуулсан хувилбарын аль нь зөв бэ?



A.  Б.  В.  Г. 

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
5.3.б. Ноот бичлэгийг харж канон, имитаци хэлбэрийг тайлбарлан дуулж хөгжимөх	Гоцлож болон хамтран ноотоор дуулж, хөгжимддөг болно.	Канон, имитаци хэлбэрт гоцлол, цөөхүүлээр дуулах, хөгжимдөх

**Сэргээн санах**

6. Даган дуурайх хэлбэрт бичигдсэн хэсгийг юу гэж нэрлэдэг вэ?

Охид   
Хөвгүүд 

- A. Имитаци      Б. Канон      В. Дахилт      Г. Давтах

**Ойлгох түвшин**

7. Ноот бичлэгийг ажиглаад өгөгдөлтэй зөв харгалзуулаарай.



Дахилт тэмдэг

Канон

Имитаци

### Хэрэглэх түвшин

8. Ноот бичлэгийг ажиглаад ноотоор дуулж хөгжимдөөрэй. Чиний бодлоор ямар хэлбэрт бичигдсэн байна вэ? Тохирохыг сонгоорой.

А. Канон

Б. Имитаци

В. Давтах

Г. Даган дуурайх

9. Өгөгдсөн хувилбаруудыг дуулж, хөгжимдөж үзээд аялгууг хэвээр хадгалж айзам хэмжээ, хэмнэл өөрчлөгдөж байгааг нь сонгоорой.

Хувилбар 1

Хувилбар 2

Хувилбар 3

А. А В С




Б. А1 А2 А3

В. А В А

Г. А В

Сонгох даалгавар 3-ын хариултын хуудасны жишээ:

– Дэвсгэр шугамд Ре, Фа диез, Ля эгшгүүдийг тэмдэглэсэн тэмдэглэлийн аль нь зөв бэ ?

Хариулт	Хариултын тайлбар	Харгалзах оноо
А	 Хувиргалын тэмдгийн талаар огт мэдэхгүй.	
В	 Энэ хувилбарыг сонгосон сурагч диез тэмдэг болон түүний үүргийг сайн мэддэгийн дээр дэвсгэр шугамд хэрхэн тэмдэглэдгийг бүрэн ойлгосон.	
С	 Сурагч диез болон бемоль тэмдгүүдийн үүргийг болоод дэвсгэр шугамд хэрхэн тэмдэглэдэг талаар эргэлзсэн.	

**Задгай даалгаврын жишээ**

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
5.3.а Эгшиг зохирлыг /консонанс, диссонанс/ сонсож таних	Хөгжмийн бүтээлийн эгшиглэгээний онцлогийг тодорхойлох	Хөгжмийн зохиолыг сонсоод эгшиглэгээний онцлогийг тайлбарлана.

**Сэргээн санах түвшин**

1. Диез тэмдгийг зураад, түүний үүргийг тайлбарлана уу.

.....

**Задлан шинжлэх түвшин**

2. Хөгжмөө анхааралтай сонсоорой. Ноот бичвэрийг ажиглаад дараах асуултад хариулаарай.

- А. Зохиолчийн нэр .....
- Б. Зохиолын нэр .....
- В. Аялгууны шинж төрх .....
- Г. Хурд .....
- Д. Хүч .....
- Е. Хөгжмийн зэмсэгжилт ?

**Carnival Of The Animals- The Elephant**  
www.klarinettennoten.info

Klarinette in B C. Saint Saens

**Үнэлэх түвшин**

3. Дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

✓ Ноотоор дуулцгаая. Хэний, ямар нэртэй дуу байна вэ? .....



- ✓ Дуулсан хэсэг дууны бадаг уу, дахилт уу?.....
- ✓ Дууны хурдыг тодорхойлж бичээрэй.

?



✓ Дуу ямар шинж төрх, өнгө аясаар дуулагдах вэ? Түлхүүр үгсийг хэрэглэн тодорхойлж бичнэ үү.

Яруу тунгалаг, хүйтэн зэврүүн, хахир хатуу, эрч хүч, баяр бахдал, бүүдгэр харанхуй, дулаан зөөлөн, хүнд бараан, гуниг харуусал, зоримог тэмүүлэл, бодол эргэцүүлэл, гэрэл гэгээ, хөгжил баясал

**Хэрэглэх түвшин**

4. а. Өгөгдсөн чиглэлийн дагуу дөрөвт ноотоор эгшигийг байрлуулж аялгуу үүсгээрэй.

б. Үүсгэсэн аялгуугаа ноотоор дуулж хөгжимдөөрэй.



4. а. Тоон тэмдэглэгээгээр бичигдсэн эгшгүүдийг дэвсгэр таван шугамд байрлуулж 2/4 хэмээр тактын зураасыг татаарай.



б. Байрлуулсан эгшгүүдээ ноотоор дуулаарай (хөгжимдөөрэй).

### Бүтээх түвшин

5. Өгөгдсөн хэмд канон хэлбэрээр хэмнэлийн дасгал зохиогоорой.



Задгай даалгавар 3-ын хариултын хуудасны жишээ: Дараах даалгавруудыг гүйцэтгээрэй.

✓ Ноотоор дуулцгаая. Хэний, ямар нэртэй дуу байна вэ? .



✓ Дуулсан хэсэг дууны бадаг уу, дахилт уу?

✓ Дууны хурдыг тодорхойлж бичээрэй.



✓ Дуу ямар шинж төрх, өнгө аясаар дуулагдах вэ?

Яруу тунгалаг, хүйтэн зэврүүн, хахир хатуу, эрч хүч, баяр бахдал, бүүдгэр харанхуй, дулаан зөөлөн, хүнд бараан, гуниг харуусал, зоримог тэмүүлэл, бодол эргэцүүлэл, гэрэл гэгээ, хөгжил баясал

Даалгаврын дугаар	Хариултын төрөл		Харгалзах оноо	Тайлбар
3	1	Дууны нэрийг мэдэж байгаа боловч зохиолчийг нэрлэж чадаагүй.	4 оноо	Дууны уран бүтээлийн зохиогчийг танихгүй байх нь их учраас тодорхой хэмжээнд танилцуулж байх хэрэгтэй.
	2	Дууны аль хэсэг болохыг тодорхойлж чадаагүй.		Ноотоор дуулах чадварыг сайжруулах
	3	Хурдыг тодорхойлж чадаагүй		Хөгжим сонсох үйл ажиллагааг хичээл сургалтад түлхүү хэрэглэх
	4	Аялгууны шинж төрх, өнгө аясад тохирохыг сонгож чадаагүй		

**Суурь боловсролын “Орчин үеийн хөгжмийн урлагийн чиг хандлага” нэгжийн төлөвлөлтийн жишээ:**

Зорилго: Орчин үеийн хөгжмөөс сонсоод урсгал чиглэлүүдийн онцлогийг тайлбарлана.

Зорилт:

- Хөгжмийн уран бүтээлүүдээс сонсоод төрсөн сэтгэгдлээ янз бүрийн аргаар илэрхийлэх
- Төрөл бүрийн аппликейшн ашиглан тодорхой сэдэвт контент, дүрс бичлэг зэргийг хийх

Агуулгын залгамж холбоо:

<i>Агуулга /Суралцахуйн зорилт/</i>	
<i>Одоо судлах агуулга</i>	<i>Дараа судлах агуулга</i>
<p><b>Орчин үеийн хөгжмийн урлагийн чиг хандлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Орчин үеийн хөгжмийн урсгал чиглэлүүд, тэдгээрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийг ялган таних, тайлбарлах</li> <li>– Найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, хэмнэл, аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлох</li> </ul>	<p><b>Монголын орчин үеийн хөгжим</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Монголын орчин үеийн хөгжмийн үүсэл хөгжил, гол төлөөлөгчид, шилдэг бүтээлийг жишээгээр тайлбарлах,</li> <li>– Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл, хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлт, тэдгээрийн холбоо хамаарлыг тайлбарлах, жишээгээр харуулах</li> </ul>

Төлөвлөлт

Суралцахуйн зорилт	Ээлжит хичээлийн зорилго	Цаг	Хэрэглэгдэхүүн	Үнэлгээний зорилт			Үнэлгээний шалгуур
				I	II	III	
9.1а. Орчин үеийн хөгжмийн урсгал чиглэлүүд, тэдгээрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийг ялган таних, тайлбарлах	Орчин үеийн хөгжмийн бүтээлийг сонсоод урсгал чиглэлүүдийг тодорхойлох Орчин үеийн хөгжмийн бүтээлийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийг ялган тайлбарлах	1  2	К.Дебюсси “Сиринокс” флейт хөгжмийн гоцлол аяз, С.Рахманинов “Вокализ” К. Орф “Кармино Бурана”				Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод, урсгал чиглэлүүдийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийн ялгааг тайлбарладаг.
9.1б. Импрессионист, экспрессионист урсгалын онцлогийг хөгжим-уран зураг-уран зохиолын бүтээлийн жишээн дээр харьцуулан тайлбарлах, сонсож таних, тодорхойлох	Импрессионист, экспрессионист урсгалын бүтээлээс сонсоод ялгааг тодорхойлох Импрессионист, экспрессионист урсгалын онцлогийг хөгжим-уран зураг-уран зохиолын жишээн дээр харьцуулан тайлбарлах	1  2	К.Дебюсси “Тэнгис”, “Болеро”, Ж.Бизе “Кармен” дуурь				Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлтүүдийг жишээгээр тайлбарладаг.

9.1в. Авангард урлаг, бүтээлч илэрхийллийн арга барилууд, тэдгээрийн онцлогийг тайлбарлах, жишээгээр харуулах	Авангард урлагийн илэрхийллийн арга барилыг тайлбарлах Авангард урлагийн онцлогийг жишээгээр тайлбарлах	2 1	П.Шеффер, Анри “Нэг хүний симфони”, А.Шёнберг “Пьеро саран” А.Берг “Воцтек”				
9.1г. Найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, хэмнэл, аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлох	Найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, хэмнэлийг сонсож тодорхойлох Найрал хөгжмийн зэмсгийн шинж төрхийг сонсож тодорхойлох	3	Бенджамин Гудмен Нарийн бүрээний гоцлол А.Онеггер “Пасифик-231”				Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлодог.
9.1д. Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл, хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлт, тэдгээрийн холбоо хамаарлыг жишээгээр тайлбарлах, харуулах	Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл, хэлбэр, холбоо хамаарлыг жишээгээр тайлбарлах Орчин үеийн хөгжмийн урлагийн илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлтийг тайлбарлах	2	Doylestown-ы симфони джаз концерт С.Сансаргэрэлтэх “Эх дэлхийгээ аварцгаая” симфони уран сэтгэмж				Орчин үеийн хөгжмийн урсгалын онцлог ялгааг хөгжим, уран зураг, уран зохиолын жишээн дээр тайлбарладаг.
9.1е. Зураг болон хөгжим, шүлгээс төрсөн сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэх, хөгжмийн илэрхийлэмжийг өөрийн санаагаар баяжуулах, тайлбарлах	Дууны аялгууны шинж төрхийг ноот бичлэгтэй холбон тайлбарлах, орчин үеийн хэв маягт зохиомжлон найруулан дуулах. Өөрийн сонирхсон хэв маяг, арга барилаар дуулах.	2	Үг Ая . С.Жамьянхорол, “Сургуульдаа өргөх дуу” Ая.Г.Эрдэнэбаатар Үг.Ц.Хүсэлбаатар “Чин хүсэл”				Бодит хөгжим бүтээсэн аргаар янз бүрийн аппликейшн, дижитал төхөөрөмж ашиглан тодорхой сэдэвт зохиомж хийж чаддаг.

“Орчин үеийн хөгжмийн урлагийн чиг хандлага” нэгжийн үнэлгээний нарийвчилсан төлөвлөгөө  
(Блюпринт)

Агуулга (Суралцахуйн зорилт)	Даалгаврын дугаар	Даалгаврын хэлбэр	Танин мэдэхүйн түвшин					Үнэлгээний зорилт						
			Сэргээн санах	Ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх (сонсголын анализ)	Үнэлэх	Бүтээх	Мэдлэг ойлгох	Гүйцэтгэх чадварын ахиц	Бүтээлчээр хөгжих чадвар	Судлах хүсэл, сонирхол, хандлага	Зөв хариулт	Оноо
9.1.а, 9.1.б, 9.1.в, 9.1.г, 9.1.д, 9.1.е	1	Сонгох	1						1					
	2	Сонгох	1						1					
	3	Сонгох	1						1					
	4	Сонгох		1					1					
	5	Сонгох		1					1	1				
	6	Сонгох		1					1	1				
	7	Сонгох		1					1	1				
	8	Сонгох		1					1					
	9	Сонгох			1				1	1				
	10	Сонгох				1			1	1				
	11	Задгай		1					1					
	12	Задгай				1			1	1				
	13	Задгай			1				1	1				
	14	Задгай						1	1	1	1			

“Орчин үеийн хөгжмийн урлагийн чиг хандлага” нэгжийн хүрээнд хийсэн даалгаврын жишээтэй танилцъя.

Сонгох даалгаврын жишээ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
9.1.а Орчин үеийн хөгжмийн урсгал чиглэлүүд, тэдгээрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийг ялган таних, тайлбарлах.	Сурагч орчин үеийн хөгжмөөс сонсоод урсгал чиглэлүүдийн онцлогийг тайлбарлаж чаддаг болно.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод, урсгал чиглэлүүдийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийн ялгааг тайлбарлах

Сэргээн санах түвшин

1. Энд хөгжмийн аль урсгалын тухай өгүүлж байна вэ ?

“Энэ үеийн хөгжмийн гол онцлог нь уламжлалт долоон эгшигт хөг цомнолоос татгалзаж 12 эгшигийг ашиглан хөгжим бүтээх аргыг нэвтрүүлсэн”.

А. Импрессионист хөгжим      Б. Экспрессионист хөгжим      В. Бодит хөгжим

2.	Экспрессионист уран бүтээлчид 12 эгшигийг ашиглан хөгжим бүтээх аргыг боловсруулсан	Үнэн	Худал
	Г.Холст “Гараг эрхсүүд” зохиол бол тайзны үзүүлбэртэй, хөгжмийн зэмсгийн хамсраатай, гоцлол ба найрал дуучдад зориулсан зохиол юм.	Үнэн	Худал
	“Бодит хөгжим” уран бүтээлчид янз бүрийн чимээ шуугиан, хүний хашхираан зэргийг бичиж хальсны эргэлтийг удаашруулах, хурдасгах зэрэг олон арга замаар авиа эгшигийг нийлүүлэн хөгжим бүтээж байв.	Үнэн	Худал

3. Бодит хөгжмийн гол онцлог нь.....

- А. Хувь хүний ертөнцийг үзэх үзлийг илүүтэйгээр илэрхийлж, тухайн үеийн хүмүүсийн эмгэнэлт хувь заяаны мөн чанарыг уран бүтээлээр дамжуулан гаргахыг эрмэлзэж байсан.
- Б. Оюун санаа, мэдрэмж, гоо сайханы ойлголтуудыг агуулж илэрхийлж байдаг мэдрэмжээ уран бүтээлд гаргахыг эрмэлзэж байсан.
- В. Хөгжмийн эгшгийн оронд амьдрал дээрх тодорхой дуу авиа, чимээ шуугианыг ашиглаж шинэ хөгжим бүтээхийг эрмэлзэж байсан.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
9.1.6 Импрессионист, экспрессионист урсгалын онцлогийг хөгжим, уран зураг, уран зохиолын бүтээлийн жишээн дээр харьцуулан тайлбарлах, сонсож таних, тодорхойлох.	Сурагч орчин үеийн хөгжмийн урлагийн шинэчлэлт өөрчлөлтийг жишээгээр харуулдаг.	Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлтүүдийг жишээгээр тайлбарладаг

### Ойлгох түвшин

4. Дараах уран бүтээлийг хэн зохиосон бэ? зөв харгалзуулан холбоорой.

- |               |                       |
|---------------|-----------------------|
| А. К. Орф     | I. “Сиринкс”          |
| Б. М. Равель  | II. “Пьеро саран”     |
| В. А. Оннегер | III. “Кармина бурано” |
| Г. К. Дебюсси | IV. “Болеро”          |
| Д. А. Шёнберг | V. “Пасифик 231”      |


5. а. Хөгжмөө анхааралтай сонсоорой. Импрессионист урсгал чиглэлээр туурвигдсан уран бүтээл аль нь вэ?

- |                         |                           |
|-------------------------|---------------------------|
| А. М.Равель “Болеро”    | Б. Рахманинов “Вокализ ”  |
| В. К. Дебюсси “Сиринкс” | Г. К.Орф “Кармина бурано” |

б. Ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсэн бэ?

- |                  |                   |            |              |
|------------------|-------------------|------------|--------------|
| I. флейт /лимбэ/ | II. төгөлдөр хуур | III. труба | IV. саксафон |
|------------------|-------------------|------------|--------------|

6. Г Холст “Гараг эрхсүүд” зохиолыг сонсох явцдаа хөгжмийн аялгуунд тохирох зураглалыг сонгоорой. /Track-32/



7. Хөгжмөө анхааралтай сонсоорой. С.Рахманинов “Вокализ” зохиол ямар хэлбэрт бичигдсэн байна вэ?

- А. найрал хөгжим    Б. найрал дуучид    В. гоцлол дуучин    Д. дээрх бүгд

8. А. Шёнберг “Пьеро саран” зохиолын онцлог нь юу вэ?

- А. Нарны аймгийн гараг эрхсүүдийн нэрээр нэрлэгдсэн ба цохивор хөгжмийн болон чавхдаст хөгжмийн нэгэн жигд хэмнэлээр эхэлж байгаагаараа онцлог юм.
- Б. Сэтгэл хөдөлгөсөн үг хэллэгийн яруу тод уншлага, бодит хашхираан болгоныг ноот бичлэгт буулгаснаараа онцлог юм.
- В. Дүрүүдийн шинж төрхийг тодорхойлоход харш хөг, хахир чохарсан аялга, этгээд хэм, дээд зэргийн хүчтэй хашхираан зэрэг хэл ярианы аялгыг ноот бичлэгт буулгаснаараа онцлог юм.

**Хэрэглэх түвшин**

9. Дасгалыг анхааралтай ажиглаарай. Синкоп хэмнэл хаана байна вэ? Сонгосон хэмнэлээ зөөлөн товшоорой.

A. 

B. 

B. 

**Задлан шинжлэх түвшин**

10. К. Орф “Кармина Бурана” уран бүтээлийг сонсоод дараах асуултын дагуу хураангуйлж тэмдэглээрэй.

1. Ямар бүрэлдэхүүнд бичсэн байна вэ? (найрал хөгжим -ардын, сонгодог, үлээвэр, чавхдаст, гоцлол, цөөхүүл) ( найрал дуучид, гоцлол дуучид )
2. Дуулаачийн аль төрлөөр бичсэн бэ? (реквием- эмгэнэлийн дуу, кантат- магтуу, оратори ялгуусан дуулал, вокализ- үггүй дуу, романс- хүүрнэл дуу, баллада- дууль)
3. Аялгууны шинж төрхийг тодорхойлоорой. (Яруу тунгалаг, хүйтэн зэврүүн, хахир хатуу, эрч хүч, баяр бахдал, бүүдгэр харанхуй, дулаан зөөлөн, хүнд бараан, гуниг харуусал, зоримог тэмүүлэл, бодол эргэцүүлэл, гэрэл гэгээ, хөгжил баясал
4. Аялга ямар байна вэ? (уриалах, асуух, хүүрнэх, )
5. Зохиол ямар цомнолд бичигдсэн бэ? (мажор, минор)
6. Аялгууны шинж төрх, өнгө аясыг тодорхойлоход хөгжмийн ямар тэмдэг тэмдэглэгээг ашигласан байна вэ? Нэрлэж бичээрэй.

*Хурдан pp*  


*Хурдан f*  


Сонгох даалгавар 8-ын хариултын хуудасны жишээ:

– А. Шёнберг “Пьеро саран” зохиолын онцлог аль нь вэ?

Хариулт		Хариултын тайлбар	Харгалзах оноо
A	Нарны аймгийн гараг эрхсүүдийн нэрээр нэрлэгдсэн ба цохивор хөгжмийн болон чавхдаст хөгжмийн нэгэн жигд хэмнэлээр эхэлж байгаагаараа онцлог юм.	Орчин үеийн хөгжмийн урсгалууд, хөгжмийн бүтээлийн бичлэгийн арга хэлбэрийн талаар сэргээн санаж бататгах шаардлагатай.	
B	Сэтгэл хөдөлгөсөн үг хэллэгийн яруу тод уншлага, бодит хашхираан болгоныг ноот бичлэгт буулгаснаараа онцлог юм.	Экспрессионизм урсгалын онцлог болоод тэр үеийн хөгжмийн уран бүтээл туурвих шинээр гарсан арга хэрэглүүр, уран бүтээлийг онцлогийг сонсож ойлгосон.	
C	Дүрүүдийн шинж төрхийг тодорхойлоход харш хөг, хахир чахарсан аялга, этгээд хэм, дээд зэргийн хүчтэй хашхираан зэрэг хэл ярианы аялгыг ноот бичлэгт буулгаснаараа онцлог юм.	Экспрессионизм урсгалын онцлог болоод тэр үеийн хөгжмийн уран бүтээл туурвих шинээр гарсан арга хэрэглүүрийг мэддэг боловч уран бүтээлчдийн уран бүтээлийн агуулгыг хооронд нь андуурсан.	



Задгай даалгаврын жишээ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
9.1.а Орчин үеийн хөгжмийн урсгал чиглэлүүд, тэдгээрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийг ялган таних, тайлбарлах.	Сурагч орчин үеийн хөгжмөөс сонсоод урсгал чиглэлүүдийн онцлогийг тайлбарлаж чаддаг болно.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод, урсгал чиглэлүүдийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийн ялгааг тайлбарлах

Ойлгох түвшин

№	Шинж төлөв	Уран сайхны чиглэл	Нотолгоо
1	Урлаг бол зүгээр нэг амьдралын хуулбар биш, харин өөртөө үзэл санаа, гоо сайхны ойлголтуудыг агуулж илэрхийлж байдаг оюун сэтгэлгээ, мэдрэмжийн ертөнц.	.....	Клод Дебюсси “Сирикс”, М. Равель “Болеро”
2	Долоон эгшигт хөг цомлоос татгалзаж 12 эгшгийн хөгжим бүтээх аргыг боловсруулсан.	.....	.....
3	Гол зорилго нь хөгжмийн эгшгийн оронд амьдрал дээрх тодорхой дуу авиа, чимээ шуугианыг ашиглаж шинэ хөгжим бүтээх явдал байсан.	.....	.....

Задлан шинжлэх түвшин

2. К.Дебюсси “Сарны гэрэл”, Л.В. Бетховен “Сарны сонат” уран бүтээлүүдийг сонсоод онцлог ялгааг харьцуулан бичээрэй.

К. Дебюсси “Сарны гэрэл”



Л.В.Бетховен “Сарны сонат”



	К. Дебюсси “Сарны гэрэл”	Л.В.Бетховен “Сарны сонат”
Хамрах хүрээ		
Аялгууны шинж төрх		
Өнгө аяс		
Хурд		
Хүч		
Хөгжмийн зэмсэг		
Айзам хэмжээ		

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
9.1.6 Импрессионист, экспрессионист урсгалын онцлогийг хөгжим, уран зураг, уран зохиолын бүтээлийн жишээн дээр харьцуулан тайлбарлах, сонсож таних, тодорхойлох	Сурагч орчин үеийн хөгжмийн урлагийн шинэчлэлт өөрчлөлтийг жишээгээр харуулдаг.	Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлтүүдийг жишээгээр тайлбарладаг.

### Хэрэглэх түвшин

3. а. М.Равель “Болеро” уран бүтээлийг сонсоод төрсөн мэдрэмжээ илэрхийлж бичээрэй?

.....

б. Хувирган хөгжүүлж байгаа хэсэг тус бүрийг ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдөж байна вэ? нэрлэж бичээрэй. ....

в. Цохиур хөгжмөөр тасралтгүй давтагдан үргэлжлэх хэмнэл аль нь вэ? Тогшиж үзээд зөв хувилбарыг сонгоно уу.

а.

б.

в



### Бүтээх түвшин

4. а. К. Дебюсси “Тэнгис” симфони чуулбарыг сонсоод төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлээрэй.

б. Байгалийн дүр зураглалыг хөгжмийн зэмсгийн дуугаралтаар хэрхэн дүрсэлж байна вэ? Тайлбарлан бичээрэй.

.....

Задгай даалгавар 3-ын хариултын хуудасны жишээ:

а. М.Равель “Болеро” уран бүтээлийг сонсоод мэдрэмжээ илэрхийлж бичээрэй?

б. Хувирган хөгжүүлж байгаа хэсэг тус бүрийг ямар хөгжмийн зэмсгээр хөгжилдөж байна вэ? нэрлэж бичээрэй.

в. Цохиур хөгжмөөр тасралтгүй давтагдан үргэлжлэх хэмнэл аль нь вэ? Тогшиж үзээд зөв хувилбарыг сонгоно уу.

Даалгаврын дугаар	Хариултын төрөл		Харгалзах оноо	Тайлбар
3	1	Уран бүтээлийг сонсож өөрт төрсөн сэтгэгдлээ бичиж, хөгжмийн зэмсгийг нэрлэн, хэмнэлийг зөв сонгосон бол	3 оноо	Эргэцүүлэн бодох алхам бүхий даалгаврыг тогтмол хэрэглэх
	2	Хөгжмийн зэмсгийн заримыг зөв нэрлэсэн боловч хэмнэлийг тогшиж чадаагүй.		Хөгжмийн зэмсгийн талаар сэргээн санах, хэмнэлээр хөгжимдөх чадварыг сайжруулах
	3	Аль алинийг нь огт хийгээгүй болон, буруу хийсэн бол		Хөгжим сонсох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хөгжмийн хэрэглүүрийн дагуу задлан шинжлэл хийх

## Гурав. Нотолгоонд суурилан шинжилгээ хийх аргачлал

Нотолгоо гэдэг нь шийдвэр гаргахын тулд тухайн нөхцөл байдлуудыг албан ёсны цогц нотлох баримтаар тогтоох танин мэдэхүйн цогцолбор үйл явцыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, дүгнэлтийн бодит үндэслэлийг хангах зорилгоор тусгай аргуудын тусламжтай цуглуулсан бүх мэдээллийг хэлдэг.

Баримт нотолгооны маш олон төрөл байх бөгөөд тэдгээрт суурилж өөрийн дүгнэлтийг хийх боломжтой юм. Дижитал технологи илүү дэлгэрч байгаа өнөөгийн нөхцөлд сурагчид төрөл бүрийн программ хангамж, бичлэг хийгч техник хэрэгсэл ашиглахыг (жишээлбэл, дуу хураагч, видео камер, дижитал микроскоп гэх мэт) ажиглаж, баримт нотолгоо болгох боломжтой юм.

Баримт нотолгоо нь сургах болон сурах үйл ажиллагааны нэг хэсэг (туршилтын ажил хийх, өгүүлэл бичих, яриа хийх, асуудлын тухай хэлэлцэх, зураг зурах, текст унших, сурах бичиг дэх асуултад хариулах, дуу дуулах гэх мэт) болсон үйл ажиллагаанаас гарах бөгөөд шалгалт, тестийн тухай асуудал биш юм.

Сурагчдад асуулт тавьсанаар шалгуурт суурилсан үнэлгээний дүгнэлт гаргах баримт нотолгоог олж авах боломжтой юм.

Сурагчдын үйлдлээр үзүүлсэн, бичсэн, хийж бүтээсэн болон зурсан гэх мэт ажлууд баримт нотолгоо болж, тэндээс тэд юу ойлгосныг олж мэдэж болно. Жишээ нь:

Анги	Шалгуур	Баримт, нотолгоо
5-р анги	Хөгжмийн зохиолыг сонсоод энгийн хэлбэрийг ялган таньдаг.	Хөгжмийн зохиолыг сонсож анализ хийнэ. Аялгуу хэрхэн өөрчлөгдөж байгааг зураглалаар илэрхийлэх эсвэл бичгээр тайлбарлах Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг сурагч ямар аргаар хэрхэн тодорхойлж байгааг багш ажиглана.
6-р анги	Хөгжмийн бүтээлийн агуулга, дүр илэрхийллийн арга барилыг ялган тодорхойлдог.	Уран бүтээлүүдийг үзэх. Дүр, дүрслэл, үйл явдлыг хэрхэн, ямар аргаар илэрхийлж байгааг тайлбарлах эсвэл бичих. Уран бүтээлийг төрлөөр нь ангилах

8-р анги	Дуурь дахь дуулаачийн урлагийн төрлүүдийг ялган таньж, хэлбэр, бүтэц, үүргийг тодорхойлдог.	Дуурийн дуулаачийн төрлүүдээс сонсох. Дуулах хэв маяг болон хэлбэрийн хувьд ямар ялгаа байгааг тайлбарлах эсвэл бичих. Сонгосон дууг дуулах
----------	---	--

Тайлбар: Энэхүү жагсаалт бол зөвхөн жишээ төдий гэж ойлгоорой.

- Бага насны сурагчдад ямар нэг зүйл бичих биш, харин ярих, аль эсвэл өөрийн санааг зургаар болон үйлээр үзүүлж харуулах даалгавар өгч болно.
- Сурагчдын практик чадварыг үнэлэхийн тулд тухайн нэг зүйлийг хэрхэн хийснийг тэднээр яриулах эсвэл бичүүлэхээсээ илүү үйлдлээр харуулах нь чухал.

**Баримт нотолгоог хэрхэн цуглуулах вэ?**


Боловсролын үнэлгээ бол сургалтаас илэрсэн баримт нотолгоонд тулгуурладаг.

Баримт нотолгоо нь

- шинэ зүйлийг танин мэдэхэд чиглэгдсэн зан байдал, чадвар, дадал хэвшил, хандлагын жишээ, түүврүүд байна.
- Хүмүүсийн маргаан, эргэлзээг арилгахад чиглэгдсэн, тэдний юу хийдгийг харуулдаг.
- шинэ мэдлэг бүтээхэд чиглэгдсэн чанарын өндөр түвшинд байх ёстой.

Баримт нотолгоо нь сургалтын зорилго, үнэлгээний зорилттой нягт уялдах ба эцсийн үр дүнг сайжруулахад чиглэгдсэн байдаг.

Баримт нотолгоонд суурилсан үнэлгээг анги танхим, сургууль, аймаг/дүүрэг, үндэсний түвшинд явуулна.



Эх сурвалж: БХ. (2020) “Суралцагчийн цогц чадамжийг тодорхойлох, хэрэгжүүлэх арга зүй” гарын авлага, тал 54

Нотлох баримт бол холбогдох нэгжийг үнэлэхэд чиглэсэн мэдээлэл бөгөөд тэдгээр нь янз бүрийн хэлбэрээр байж болохоос гадна олон эх сурвалжаас цуглуулж болдог гэдгийг байнга санах хэрэгтэй. Уламжлалт үнэлгээний баримт нотолгоо нь улсын шалгалт, чанарын үнэлгээний судалгаа, Элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ) зэрэг үндэсний түвшний шалгалт судалгаанаас гарч, дээрээс доош чиглэсэн хандлагатай байдаг. Харин 21-р зууны боловсролын үнэлгээний баримт нотолгоо нь эсрэгээр анги танхим дахь үнэлгээ (сурагчийн өөрийн үнэлгээ, багшийн үнэлгээ)-ээс бий болж, доороос дээш чиглэсэн хандлага давамгайлдаг болсон.

Энэ нь бодит гүйцэтгэлээр, найдвартай илрүүлэхэд анхаарч суралцагч тухайн орчин нөхцөлд мэдлэг чадвараа хэрхэн хэрэглэж байгаа, хандлага зан үйл нь хэрхэн өөрчлөгдөж байгааг илрүүлэхэд төвлөрдөг.

### Баримт нотолгоог цуглуулах хэлбэр

Баримт нотолгоог цуглуулахад хичээлийн жилийн үйл ажиллагааг эргэн харж үнэлэхээс эхэлнэ. Энэ нь сургалтын хөтөлбөрийн агуулга хэрэгжээгүй шалтгааныг тодруулж, шийдвэрлэн ирэх жилийн агуулга, арга зүйгээ сайжруулахаар явуулж буй үнэлгээ юм. Энэхүү үнэлгээг хийхийн тулд баримт нотолгоог цуглуулж шинжилгээ хийх хэрэгтэй ба нотолгоог цуглуулахын тулд дараах хэдэн судалгаа тогтмол хийгдэнэ. Үүнд:

8. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх

- o сургалтын орчин, сурах бичиг, хэрэглэгдэхүүний хангалт, аюулгүй байдлын судалгаа хийх
- o хичээлийн судалгаа хийх
- o суралцагчдад арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах

Эдгээр судалгаанаас гадна дараах хэлбэрүүдээр сургалт, үйл ажиллагааны талаарх баримт нотолгоог цуглуулна.




Эх сурвалж: Г.Баярмаа (2016) "Үнэлгээ, үнэлгээний даалгаварт тавигдах шаардлага" сургалтын материал

### А. Анги танхим дахь түвшний үнэлгээний баримт нотолгоог цуглуулах

Баримт нотолгоог хамгийн бодитой, үр дүнтэй цуглуулах боломж олгодог анги танхим дахь үнэлгээ нь суралцагчийн өөрийн үнэлгээ, багшийн (хөндлөнгийн) үнэлгээгээр хэрэгжинэ. Жишээ нь:

- Онцгой үйл явдлын талаарх сурагчийн тайлан
- Гүйцэтгэлийн чанарыг оноожуулах/дүн тавих
- Санал бодол, үнэлэмж, хандлагыг нь асуух
- Ажиглалтыг кодлох (асуусан асуултын тоо)
- Видео бичлэгт ажиглалт хийх





**Б. Сургуулийн түвшний үнэлгээний баримт нотолгоог цуглуулах**

Сургуулийн зорилго, зорилт биелсэн эсэхийг тодорхойлох үйл явц нь сургуулийн үнэлгээ юм. Сургууль жилийн эсвэл хэд хэдэн жилийн зорилго зорилтоо тодорхойлсны дараа тэдгээрийг үнэлэх үнэлгээний шалгуурыг тогтооно.

Сургуулийн үнэлгээ нь сургалтын чанарын баталгаа, чанарыг дээшлүүлэх, сургуулийн менежментийг сайжруулах, итгэл хүлээсэн нээлттэй сургууль болох хөшүүрэг болдог.


Сургуулийн түвшинд хөндлөнгийн болон явцын, оношлох, үр дүнгийн үнэлгээгээр баримт нотолгоог цуглуулах боломжтой юм.

**В. Баримт нотолгоог хялбар байдлаар цуглуулах боломжтой нээлттэй эх сурвалж, апп**



ZipGrade, Padlet, Quizlet, Duolingo App, Google classroom, Google site, Google forms, slido.com, SPSS, Microsoft Excel Worksheet-ыг хэрэглэх боломжтой юм.

Эдгээрээс Kahoot утасны апп болон компьютер дээр ажиллаж мэдээлэл цуглуулах аргачлалыг танилцуулья.



- Sign up- хийж энэ апп-д бүртгүүлнэ.
- Create – хэсгийг дарж шинээр асуултын сан үүсгэнэ. Бусад улбар шар тэмдэгтэй хэсгүүд нь төлбөртэй тул нээгддэггүй зөвхөн эхний NEW Kahoot л үнэгүй болохыг анхаарна уу.
- Kahoot-д зөвхөн 2 төрлийн асуулт зохиох боломжтой. 1. Тест буюу сонгох 2. Зөв бурууг сонгох
- Click to start – хэсэг дээр асуултаа бичнэ. Дөрвөн өнгөтэй хэсэг дээр хариултаа бичнэ.
- Add question-ийг дараад дараагийн асуултаа бичнэ. 2 сонголт гарч ирнэ. Тест /QUIZ/ болон зөв буруу /TRUE or FALSE/ гэсэг дасгалаас аль нэгийг сонгоно.
- True or False буюу зөв бурууг сонгох дасгалын үйл явц. Ногоон өнгөөр чагталсан нь зөв хариулт гэсэн үг.
- Бүх асуултаа оруулж дууссаны дараа баруун дээд буланд DONE гэсэн үгийг дарна. Энэ нь тестээ хадгалах хэсэг юм.

- Done-ийг дарсны дараа хүснэгт гарч ирнэ. Title – хэсэгт сэдвээ description- хэсэгт тайлбараа бичнэ.
- Ийнхүү тестийн санд шинээр тест нэмэгдэж дэлгэцэнд гарч ирнэ. Play-товчийг дарж тестээ суралцагчдад тоглуулна. Энэ үед бүх суралцагчид нэгэн зэрэг тоглох ёстой ба бүгдээрээ оролцоход бэлэн байх хэрэгтэй гэсэн үг.
- Play хэсгийг дарснаар танд хүснэгт гарч ирнэ. Эхлээд Choose a way to play буюу тоглуулах аргаа сонгон TEACH-ийг сонговол бүх сурагч нэгэн зэрэг оролцох ба тестээ нэгэн зэрэг гүйцэтгэнэ. Харин assign- дарвал хүүхдүүд хүссэн үедээ орж даалгавраа гүйцэтгэнэ. Онлайнгаар тоглуулж байгаа тохиолдолд teach-ийг сонгох нь зүйтэй. Teach-ийг сонгосны дараа Classic гэснийг сонгоно.
- Үүний дараа танд PIN код гарч ирнэ. Энэхүү Пин кодыг суралцагчдад хэлж өгөх ба ингэснээр тэд таны тестэд нэвтрэх эрхээ авна. Суралцагчид бүгдээрээ өөрсдийнхөө нэрээ бичиж орсны дараа та start товчлуурыг дарж тоглоомоо эхлүүлнэ. Жич: нэг асуултын хугацааг та сонгох боломжтой 5 секундээс эхэлнэ.

### **Баримт нотолгоог хэрхэн шинжлэх вэ?**

#### **Сургалтын талаарх баримт нотолгоонд хэрхэн дүн шинжилгээ хийх (анализ) вэ?**

- Онцгой үйл явдал, тооны давтамжийг зөв тоолох
- Юу юу болсон тухай checklist, тэдгээрт зарцуулсан хугацаа
- Рубрик зохиох, оноожуулах
- Үйл явдлын талаарх сурагчийн тайлан
- Ажиглалтыг кодлох (асуусан асуултын тоо)
- Видео бичлэгт ажиглалт хийх
- Гүйцэтгэлийн чанарыг оноожуулах/дүн тавих
- Санал бодол, үнэлэмж, хандлагад өгсөн дундаж оноог шинжлэх

#### **Гэхдээ**

- зарим төрлийн баримт нотолгоонд анализ хийхэд бусдаасаа арай хялбар байдаг. Жишээ нь: Уншсан үгийн тоо, бодсон бодлогын тоо, Checklist, гэрийн даалгаврын гүйцэтгэсэн хувь, дундаж үнэлэмж /rating/
- зарим төрлийн баримт нотолгоог тоон дата болгон буулгахад бусдаасаа арай хялбар байдаг.
- зарим төрлийн баримт нотолгоонд анализ хийхэд бусдаасаа илүү төвөгтэй болохыг байнга санаж байх хэрэгтэй. Жишээ нь: Хичээлийн видео бичлэг, ангийн ажиглалт, эсээ, богино бичих хариулт, аман илтгэл, хэлэлцүүлэг

Сурагчдын гүйцэтгэлд шинжилгээ хийхдээ дараах алхмаар шинжлээд, хичээлийн агуулга, арга зүйгээ тодорхойлно. Шинжилгээ хийсний дараа сурагчдын ойлгоогүй, дутуу ойлгосон, алдаа зэрэг нь ялгаатай гарах тул бататгах агуулга, арга зүй ч өөр өөр байх болно. Үүнд:

а. Мэдээлэл цуглуулах. Хэрвээ багш сурагчдын даалгаврын оноо, гүйцэтгэлийг гаргаж оношлох шаардлагатай гэж үзвэл дараах хүснэгтийн дагуу мэдээлэл цуглуулах боломжтой. Энэ хүснэгтийг аль ч түвшний эцсийн үнэлгээнд хэрэглэхэд тохиромжтой.

..... аймгийн ..... сургуулийн ..... дугаар ангийн суралцагчдаас ..... хичээлээр  
авсан **хөндлөнгийн** шалгалтын мэдээлэл

№	Сургуулийн нэр	Сурагчийн нэр	Даалгаврын дугаар											Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь
			1	2	3	4	5	6	7	8	9	10	...		
1		Н.Амар	A	B	C	D	B	B	D	B	A	C	...		
2		С.Бат	C	B	A	D	C	B	D	C	C	C	...		
3		Б.Долгор	B	A	D	B	C	D	A	A	C	B	...		
4													...		
5													...		
6													...		
7													...		
8													...		
9													...		
10													...		
<b>Даалгаврын гүйцэтгэлийн хувь</b>															
A хариултыг сонгосон сурагчийн тоо															
B хариултыг сонгосон сурагчийн тоо															
C хариултыг сонгосон сурагчийн тоо															
D хариултыг сонгосон сурагчийн тоо															

Сонгох даалгаврын нотолгоонд дүн шинжилгээ хийхдээ багш нар ихэвчлэн тоо, хувийг гаргадаг. Гэтэл тоо, хувиас илүүтэй сурагчид аль даалгаврыг буруу, гүйцэд хийгээгүй байна гэдэгт анхаарлаа хандуулах ёстой юм. Өөрөөр хэлбэл, сурагчдын буруу хариултад шинжилгээ хийж түүний үр дүнгээр дараагийн үйл ажиллагаагаа төлөвлөж, сайжруулах ажлыг хийнэ гэсэн үг.

б. *Буруу хариулт, алдааны шалтгааныг оношлох, таамаглал дэвшүүлэх.* Сурагчдын яагаад буруу хариултыг сонгосон, ташаа ойлголттой байна бэ гэдгийг илүү нухацтай гаргах хэрэгтэй.

в. *Шийдвэрлэх арга замыг дэвшүүлэх.* Даалгаврын гүйцэтгэл, сурагчдын нийтлэг гаргаж байгаа алдаа, ташаа ойлголтод суурилан анги нийтэд бататгах, мөн хэсэг бүлгээр бататгах, сурагч нэг бүрт эргэх холбоо өгөх гэх мэтээр ажиллана.

г. *Бататгах хичээлийг төлөвлөх.* Анги тус бүрийн жишиг төлөвлөлтийг сайжруулах замаар дараа дараагийн хичээлийг төлөвлөж түүний дагуу хичээл сургалтыг явуулна.

д. *Хичээлээ сайжруулах.* Шинжилгээний үр дүн, хэрэгжилт, туршлагаасаа дараа, дараагийн хичээлийг сайжруулах санааг тэмдэглэн хэрэгжүүлнэ.

**Дүгнэлт гаргах**

Шалгуурт суурилсан үнэлгээг хийхдээ багш та сурагчийг шалгуур үзүүлэлтэд хүрсэн болон хүрч буй эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах болно. Шалгуурт хүрсэн гэдэг дүгнэлтийг хэд хэдэн хичээлийн явцад сурагчийг ажигласны дараа бие даан хийж чаддаг болсны дараа гаргана. Дүгнэлтийг хийхдээ сургалтын үйл ажиллагаан дээр үндэслэж хийнэ гэдгийг анхаарах хэрэгтэй (энэ бол тест, шалгалт биш).

Сурагч шалгуурыг бие дааж хийх чадвартай болсон гэдэгт та бат итгэлтэй болсон бол тухайн сурагчийг шалгуурт хүрсэн гэж дүгнэнэ.

**Дүгнэлтээ тэмдэглэх**

EXCEL программын хуудас дээр шалгуурт суурилсан үнэлгээний тэмдэглэгээг хийх боломжтой. Түвшин бүрт 1 excel хуудас байж болно. Хэрэв та хэд хэдэн ангид заадаг бол тус хуудсыг анги тус бүрт зориулж, хуулбарлах хэрэгтэй болно. Excel хуудас тус бүр хэд хэдэн дэд хуудастай. Дэд хэсэг бүр нь тус хичээлийн сэдэв бүрийг илэрхийлнэ. Хамгийн сүүлийн хүснэгт нь тухайн ангийн явцын тухай ерөнхий мэдээллийг агуулна.



Excel хуудсыг нээхэд дараах дүр зураг харагдана.

Баруун гар талын дээд хэсэгт хичээлийн нэр, доод хэсэгт нь сурагчдын нэр болон анги, суралцахуйн зорилт харагдана. Мэдээллийг та өөрөө оруулна.

The screenshot shows an Excel interface with a header section containing filters for 'Хичээл' (Subject) and 'Анги' (Class). Below this is a grid for 'Хэлбэр' (Form) with columns for subjects (Ref, шалгуур, etc.) and rows for evaluation criteria. A summary table on the right shows 'Ангийн суралцагчийн тоо' (Number of students in the class) for various criteria, with a total of 51 students.

Нэгжид харгалзах шалгуур өгөгдсөн байна. 5 дугаар ангийн “Хэлбэр” нэгжийн шалгуурыг ашиглаж, тэмдэглэгээ хийхээр орууллаа.

Ref	шалгуур	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Хөгжмийн бүтэцлэлийг сонсоод төрөл зүйлийг тодорхойлдог	X														
2	Удирдаачийн дохиогоор гоцлол, найрал хэлбэрт дуулдаг	0														
3	Хурд хүний өөрчлөлтийг мэдэрч удирдаачийн дохиогоор хөгжмддөг															
4	Хөгжмийн зохиолын агуулга дүрийг бүхийн дасгалар илэрхийлдэг															X
5	Хөгжмийн зохиолыг сонсоод сэтгэгдлээ /өнгө будаг, зураглалаар/илэрхийлдэг														A	
6																
7																
8																
9																
10																
11																
12																X
13																
14																
15																

The legend defines the evaluation scale:

- 3** (Green): Шалгуурт хүрсэн
- 2** (Yellow): Шалгуурт хүрэхийн төлөө ажиглаж байгаа
- 1** (Blue): Шалгуураар үнэлэгдээгүй сурагчид
- 0** (Light Blue): Заагдаагүй байгаа сурга

Хичээл бүрийн төгсгөлд шалгуурт суурилсан үнэлгээний үр дүнг бичиж тэмдэглэхгүй. Гэсэн хэдий ч түүнийгээ хадгалж байвал төлөвлөлт хийхэд чинь хамгийн их хэрэг болох болно. Тэмдэглэлийг шинэчилэх давтамж сурагчдын нас, зааж буй хичээлээс хамаарна. Хамгийн багадаа улирлын төгсгөлд тэмдэглэлээ сайжруулах хэрэгтэй.

Таны тэмдэглэл хичээл дээр яг юу болж байгааг харуулж байх нь чухал. Та бүх сурагчийг шалгуурын дагуу ажиглаж чадахгүй байгаа бол тэр тухайгаа ч мөн бичих хэрэгтэй. *Жишээлбэл:*

Сурагч 1 нь “Хөгжмийн бүтээлийг сонсоод төрөл зүйлийг тодорхойлдог” гэсэн шалгуурт хүрчихсэн байгааг та харж байна. Цэнхэр өнгүүд нь багш зарим сурагчдыг үнэлж амжаагүй гэдгийг харуулж байна. Сурагч 6 энэ шалгуураар үнэлэгдээгүй байна. Энэ нь байж болох зүйл. Учир нь тэр хичээл дээр байгаагүй эсвэл өвчтэй байсан гэсэн үг юм.


Хөндлөнгөөр нь харах юм бол “Удирдаачийн дохиогоор гоцлол, найрал хэлбэрт дуулдаг” гэсэн шалгуурт бүх сурагчид цэнхэр авсан байна.

Эндээс багш сэдвийг заасан нь харагдаж байгаа боловч сурагчдыг үнэлж чадаагүй байна (энэ улиралд цаг байгаагүй байж магадгүй). Энэ багш хичээлийн жилийн төгсгөлөөр эдгээр сурагчдыг үнэлэх зорилготой байгаа.

шалгуур	1	2	3	4	5
Хөгжмийн бүтэцлэлийг сонсоод төрөл зүйлийг тодорхойлдог	X	X	X	X	X
Удирдаачийн дохиогоор гоцлол, найрал хэлбэрт дуулдаг	Y	Y	Y	Y	Y
Хурд хүний өөрчлөлтийг мэдэрч удирдаачийн дохиогоор хөгжмддөг	0	0	0	0	0
Хөгжмийн зохиолын агуулга дүрийг бүхийн дасгалар илэрхийлдэг	X	X	X	A	X
Хөгжмийн зохиолыг сонсоод сэтгэгдлээ /өнгө будаг, зураглалаар/илэрхийлдэг	X	X	A	X	X

Гэвч үргэлж ийм боломж олдохгүй. Хэрэв ангид заагдаагүй ямар нэг шалгуур байвал тэр мөрөнд “0” тавина. Жишээлбэл: “Хурд хүчний өөрчлөлтийг мэдэрч удирдаачийн дохиогоор хөгжимддөг” гэсэн сэдвийг ангидаа заагаагүй байна. Та хөтөлбөрийн агуулгыг бүтнээр заахыг хичээх хэрэгтэй. Ингэвэл хүснэгт цөөн “0”-тэй байх болно.

Тухайн хичээлийн шалгуурын тоо	5							
Заагдаагүй байгаа сэдвийн шалгуурын тоо	1	1	1	1	1	1	1	1
Үнэлэгдэхгүй шалгуурын тоо	1	1	1	1	1	3	1	1
Хүрэхийн төлөө ажиллаж байгаа шалгуурын тоо	0	0	0	2	2	1	0	1
Хүрсэн шалгуурын тоо	3	3	3	1	1	0	3	2



Хүснэгтээ бөглөчих юм бол автоматаар нийлбэр нь бодогдох ба та үүнийг хүснэгт бүрийн баруун гар талд харах болно. Шалгуур тус бүрт “Сэдвийг үзээгүй байгаа, шалгуураар үнэлэгдээгүй, шалгуурт хүрэхээр ажиллаж байгаа, шалгуурт хүрсэн” гэсэн үзүүлэлт бүрээр ангийн сурагчдын нийлбэр гарна.

Дугуй диаграммд энэхүү мэдээллийг нэгтгэн харуулна. Хуудас бүрийн төгсгөлд сурагч бүрээр нийлбэр нь гарна. Энэ мэдээллийг сурагчийн талаарх тайланд ашиглана.

Та зөв нүдэнд зөв тоо оруулах, үр дүнг гаргахдаа маш болгоомжтой байх нь чухал. Хүснэгтийн нүдэнд 0, X, A, Y-ээс өөр үсэг, дүрс бичигдвэл цагаан өнгөтэй болж харагдана.

Үнэлгээний нэгж бүрээр таны тэмдэглэсэн мэдээлэл автоматаар нэгтгэгдэх болно. Хамгийн сүүлчийн дэд хүснэгтэд бүтэн хичээлийн жилийн туршид сурагч бүрт гарсан ахицын талаар дүгнэлт бичих боломжтой. Таны тэмдэглэл нь сурагчдын талаарх мэдээлэл болон ахицын талаар маш их зүйлийг агуулж байх ёстой.

Та шалгууруудын хагасыг нь ч болов ашиглан хичээлээ үнэлж байх хэрэгтэй. Үүнд заадаг хичээлийнхээ бүх нэгжийн шалгууруудаас багтаасан байх нь зүйтэй гэдгийг санаарай.

Бид сурагчийн мэдлэг, чадварыг оношлох, үр дүнг боловсруулахад дөхөм болгох үүднээс үнэлэх аргачлал бүхий “Excel” файл бэлтгэсэн бөгөөд та бүхний хэрэгцээнд тулгуурлан уг файлд томъёо оруулсан тул, ашиглахад хялбар болно.

Excel хүснэгтээ гаргахдаа гар утсандаа QR аппликейшн татаж суулгасан байх хэрэгтэй ба энэхүү QR кодыг гар утсаараа уншуулж, холбоосыг интернетийн орчинд хуулахад *hugjim shalguur* холбоос гарч ирнэ. Энэ холбоос руу ороход үр дүнг тэмдэглэх excel файл байх ба түүнийг татаж аваад сурагчдын мэдлэг, чадварын үр дүнг оруулах боломжтой.




**Баримт нотолгоог хэрхэн ашиглах вэ?**

Баримт нотолгоо, дүгнэлтэд суурилан нэгж, ээлжит хичээлийн төлөвлөгөөг сайжруулах, авах дэмжлэгийг тодорхойлох, сургуулийн удирдлага, олон нийтэд ил тодоор мэдээлж дэмжлэг авах ажлуудыг зохион байгуулна.

Мэдээллийн технологийг хэрэглэн үнэлгээний баримт нотолгоо, дүгнэлтийг ил тод байлгах үйл явцыг сиситемтэйгээр хөгжүүлбэл сургуулийн үнэлгээний “Дата” үүсэж аль ч түвшинд хэрэглэх боломжтой болно.

Үнэлгээний баримт нотолгоог ашиглах түвшин хоорондын мэдээллийн урсгалыг зураглалаар үзүүлэв.



Эх сурвалж: БХ. (2020) “Суралцагчийн цогц чадамжийг тодорхойлох, хэрэгжүүлэх арга зүй” гарын авлага, тал 67

### Баримт нотолгоо ямар ач холбогдолтой вэ?

Багш үйл ажиллагааны онцлог бүрт тохирсон баримт нотолгоог цуглуулж, тэдгээрийг цаашдын төлөвлөлтөд ашиглах төдийгүй нотолгоонд суурилсан тодорхой зорилтууд, сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлох, сургах, суралцах арга барилыг сайжруулж хэрэгжүүлэхэд тусалдаг. Тухайлбал, багшийн өөрийн үнэлгээг тодорхой зорилготой төлөвлөн хэрэгжүүлбэл илүү бодитой, үр дүнтэй баримт нотолгоог цуглуулах болно. Жишээ нь:

- Би хэр сайн ажиллаж байна вэ?
- Бидний давуу тал юу вэ?
- Би хэрхэн илүү сайн хийх вэ?
- Бид хэрхэн сайжруулах вэ?
- Миний сайжруулах талбар юу вэ?

Эцэст нь хэлэхэд үнэлгээ /Assessment/ нь асуудлыг илрүүлэх зорилготой бөгөөд багшийн заах аргатай холбоотой илэрсэн асуудлыг сайжруулахын тулд хийгддэг үйл ажиллагаа гэдгийг ойлгож, ач холбогдол өгч ажиллах хэрэгтэй.

Үнэлгээний шалгуураар хөтөлбөрийн зорилтын биелэлтийг илрүүлж, хэрэгжилтийн дүнгээс асуудлаа тодорхойлж, шийдвэрлэх, сайжруулах нь бидний үндсэн ажлын нэг хэсэг байх болно.

## НОМ ЗҮЙ

1. “Хөтөлбөрийн менежментийн циклийн үйл ажиллагааг эрчимжүүлэх сургалт”-ын материал., Жайка, (2017)
2. “Сургалтын материалын эмхэтгэл” гарын авлага., Жайка, (2018)
3. Үнэлгээ, үнэлгээний даалгаварт тавигдах шаардлага сургалтын материал., БХ, (2018)
4. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг хэрэгжүүлэх зөвлөмж, УБ., БҮТ, (2018)
5. Зөвлөн туслах ажлын материал., БХ, (2019)
6. ЕБС-ийн сургалтын хөтөлбөр-багшийн заах арга зүй-үнэлгээний чадавхийг бэхжүүлэх сургалтын материал., Койка, (2020)
7. Суралцагчийн цогц чадамжийг тодорхойлох, хэрэгжүүлэх арга зүй., БХ, (2021)
8. Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх гарын авлага., ҮСХ (2017)
9. Блюпринт болон даалгавар боловсруулах арга зүй сургалтын материал., БҮТ (2020)
10. “Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ боловсруулах нь” Нэнси П.Галлаван
11. “Үнэлгээ, үнэлгээний даалгаварт тавигдах шаардлага” сургалтын материал., Г.Баярмаа (2016)
12. Сонгох-хариултат даалгаврыг шинжлэх аргазүйн нэгэн хувилбар (ЭЕШ-ын химийн даалгаврын жишээн дээр) докторын ажил., Нямгэрэл, Ч.(2016)



**ЕБС-ийн Хөгжим хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:**

Х.Энхжаргал	Боловсролын хүрээлэн, БХСС, ЭША, магистр
Б.Баттуяа	Баруун урт сумын 4-р сургуулийн хөгжмийн багш

**Хөндлөнгийн шинжээч:**

Ч.Оюунбилэг	СУИС-ийн ХУС-ийн БУБ-ийн тэнхимийн багш, доктор (Ph.D)
-------------	--

**Техникийн редактор:**

Г. Дэлгэрмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D)
Ш.Сувдмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

С.Мөнхмаа	Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр
-----------	--------------------------------------

**Цаасны хэмжээ:** А4

**Хэвлэлийн хуудас:** 5.5 х.х



*Дэлгэрэнгүй мэдээллийг:*

[www.eec.mn](http://www.eec.mn)



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,  
Утас/Факс: 976-11 7011- 8486  
И-майл: [info@eec.mn](mailto:info@eec.mn) Вэб: [www.eec.mn](http://www.eec.mn)